



“ХАШААТЫН ЦАВ” ХҮРЭН НҮҮРСНИЙ ИЛ УУРХАЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН



ДОРНОД, БАЯНТҮМЭН СУМ

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	“Хашаатын цав” хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл
Байршил:	Дорнод аймаг, Баянтүмэн сум
Төсөл хэрэгжүүлэгч:	“Меланж” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011256001
Регистрийн дугаар:	5412153
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-8 , Алтай бьюлдинг, 3 давхар, 302 тоот
Утас:	+976-11-
Факс:	+976-11-
Цахим хаяг:	envr@khashaatcoal.mn :
Хариуцах хүн:	Байгаль орчны мэргэжилтэн . Утас: 95100426, 80550426
БОНЕУ, шийдвэрийн төсөл:	2020 оны 08 сарын 09-ны 2013/А62 дугаар БОНЕУ–ний дүгнэлтийг гаргасан.
БОННУ хийсэн ААН-ийн нэр, батлуулсан огноо:	Тус төслийн БОННУ-г “ЭКОТАЙКҮҮН” ХХК хийж гүйцэтгэсэн. 2021 он

АГУУЛГА

1.	Төслийн товч танилцуулга	
1.1	Төслийн нэр	4
1.2	Төслийн зорилго	4
1.3	Төсөл хэрэгжүүлэгчийн талаар мэдээлэл	4
1.4	Төслийн талбайн байршил	4
1.5	Ажиллах хүчний тухай мэдээлэл	5
2.	Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдал	6-8
3.	Уурхайн үйл ажиллагааны тухай	9-14
3.1	2022 оны уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл	9
3.2	Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц	10
3.3	Төсөлтэй холбогдох тусгай зөвшөөрөл, гэрчилгээ	14
3.4	Байгаль орчны үнэлгээний тайлангууд	14
3.5	2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлангийн бүтэц	14
4.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний товч тордорхойлолт	15
4.1.	Төслийн гол болон болзошгүй нөлөөллүүд, бууруулах арга хэмжээ	15
5.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	18-
5.1.	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний биелэлт	18-23
5.2.	Газрын гадарга, газрын хэвлийн үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	24-29
5.3.	Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл	30-38
5.4.	Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	39-43
5.5.	Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	44-51
6.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	52-
6.1.	Уурхайн шимт хөрсийг ургамалжуулсан ажил	52-55
6.2.	Тэрбум мод хөтөлбөрийн хүрэн ногоон төгөл байгуулах ажил	56-57
6.3.	Ашиглалтын талбайд хийгдсэн геотехникийн судалгааны ажлыг нөхөн сэргээлт хийсэн ажил	58
7.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	58
7.1.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах Тарвага нутагшуулсан ажил	58-66
7.2.	Эдвэрсэн газат техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэсэн ажил	66-69
8.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	70
9.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	77-78
10.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	79-77
11.	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	78
12.	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	81
12.1.	Агаарын чанарын хяналт, шинжилгээ	81-90
12.2.	Уурхайн усны хяналт, шинжилгээ	91-92
12.3.	Хөрсний бохирдлын хяналт, шинжилгээ	93-97
13.	Дүгнэлт	97-100
14.	Хавсралт	115

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр: “Хашаатын цав” нэртэй хүрэн нүүрсний орд ашиглах төсөл

1.2. Төслийн эрхэм зорилго:

Хашаатын цав нэртэй хүрэн нүүрсний ордыг байгаль орчинд аль болох сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглан Монгол улсын эрдэс баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд төслийн гол зорилго оршино.

1.3.Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын товч танилцуулга:

Төсөл хэрэгжүүлэгч нь 2010 онд геологи, уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх, үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлээр, мөн гадаад худалдаа, зуучлал, уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа, геофизикийн судалгаа зэрэг туслах чиглэлүүдтэйгээр байгуулагдсан.

2017 онд АМГТГазраас зарласан Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших Хашаатын цав нэртэй газар сонгон шалгаруулалтад оролцон шалгарч тус газар геологи хайгуулын иж бүрэн судалгааны ажлыг хийн гүйцэтгэн нүүрсний орд газрыг нээн илрүүлж ашиглалтад бэлдээд ажиллаж байна.


“Меланж” ХХК нь MV-020936 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшдэг ба уг тусгай зөвшөөрлийн талбайд 2017 онд өөрийн хөрөнгөөр хайгуул хийн нөөцийг ЭБМЗ-өөр батлуулсан. Тухайн ТЭЗҮ-ийн дагуу уурхайн ашиглалтыг 2021 оны 12 сараас эхлэн хөрс хуулалтын ажил эхүүлсэн байна.

1.4. Төслийн байршил:

MV-020936 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хашаат цав”-ын хүрэн нүүрсний нүүрсний орд нь Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт К-47-35 дугаар планшитэд 3977.24 га талбайг хамран оршино. Төслийн талбай нь Чойбалсан хот ба Баянтүмэн сумаас зүүн урагш 70 км, Дорнод аймгийн Матад сумын төвөөс хойш 94 км, Улаанбаатар хотоос зүүн зүгт 742 км зайтай.

Хүснэгт 1. MV-020936 тоот тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүд

Д/д	Уртраг			Өргөрөг		
	Град	мин	сек	град	мин	сек
1	115	32	0	47	55	15.23
2	115	26	15	47	55	15.23
3	115	26	15	47	58	15.19
4	115	32	0	47	58	15.1



Зураг 1. Хашаатын цав хүрэн нүүрсний ил уурхайн байршил зураг

1.5. Ажиллах хүчний тухай мэдээлэл

“Хашаатын цав” уурхайн үйл ажиллагаа эхэлсэн хугацаанаас нийт 485 хүн ажилласан байна. Тухайн ажилчид инженер техникийн болон бусад ажилчдыг УБ болон орон нутгаас авч ажиллуулж байна. Ажилчид нь уурхайд 14 хоног ажиллах 14 хоног амрах хуваарьтай байна. Төслийн талбайд 11 сарын байдлаар 321 нийт ажилчид байна. Туслан гүйцэтгэгч “КА групп” ХХК нь 179 ажилчидтай, “МУС” ХХК нь 107 ажилчидтай, “Меланж” ХХК болон бусад компаниуд 40-н ажилтантай байна.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Физик газарзүй

Монгол орны нутаг дэвсгэрийн гадарга нь Сибирийн өмнөд уулсаас Төв Азийн тал газарт шилжих шилжилтийн мужид, умарт зүгийн хүйтэн чийглэг уур амьсгалаас өмнө зүгийн хэт хуурай уур амьсгалд шилжих алгуур шилжилтийн нөхцөлд бүрэлдэн тогтсон байна.

Уул зүй

“Хашаатын цав” хайгуулын талбай нь Дорнод талын их мужийн Мэнэнгийн талархаг дэд мужид хамаарах ба далайн түвшнээс дээш 570-800м-ийн өндөрт оршино. Газрын гадаргын байдал нь нам гүвээт талархаг, хэдэн арван метр харьцангуй өндөртэй ухаа гүвээт тал зонхилох ба тэдгээрийн хооронд жижиг хотос болон тэгш гадарга оршдог. Талбайн өмнө талд Нүүрст-Уул (727.6м), Хашаатын цав (792.7м) зэрэг өндөрлөгүүд, Баян-Усны хонхор, Их, Бага халуун шаварт нуурын хөндий (572.9м), Ар хашаатын цайдам зэрэг хотгорууд ялгагдана. 100 орчим метрийн харьцангуй өндөршилтэй толгодлог гадаргуу нь нэгээс хоёрдугаар эрэмбийн усан хагалбаруудыг үүсгэдгээс Хашаат цавын нэгдүгээр эрэмбийн усан хагалбар нь Хэрлэнгийн ай сав, Халх гол-Нөмрөгийн ай савыг заагладаг Дорнод Монголын гол усан хагалбар юм.

Цаг уур

Талбай нь нилээд өргөгдсөн тэгш өндөрлөгт хамаарах бөгөөд дэлхийн уур амьсгалын бүсчлэлээр хойд сэрүүн бүсэд харьяалагдан, далай тэнгисийн зүгээс ирэх чийглэг дулаан уур амьсгал Хянганы уулсаар хаагдсаны улмаас эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилд унах хур тунадасын хэмжээ бага байдаг. Судалгааны талбайн (ер нь Дорнод Монголын) цаг уурын төлөв байдал нь нэгэнт эх газрын эрс тэс шинжтэй тул өвлийн улирал нь урт хүйтэн, зун нь богино дулаан, харин хавар намрын улирал нь богиновтор хэр нь хүйтний солилцоо их байдаг. Хамгийн дулаан байх үе нь 7-р сард, хүйтэн нь 1-2-р сард тохиолдоно. Жилийн дундаж температур 0оС+2оС ба хамгийн хүйтэн байх хоёрдугаар сарын дундаж температур +20°С байдаг. Баруун хойноос болон зүүн хойноос чиглэлийн салхи зонхилох ба Төв Азийн Сибирийн максимаас үүсэлтэй антициклон голлох үүрэгтэй. Зуны эхнээс өндөр даралттай муссон салхины үе эхэлдэг.

Орон нутгийн чанартай говийн салхи зуны төгсгөлд онцлогтой. Салхины хурд 30-50 км/цаг хүрэх нь бий. Өвөл 11-р сард эхэлж, 3-р сарын сүүлчээр хаврын урь орох, 6-р сард зуны улирал эхлэн 8-р сарын сүүлчээс намрын уур амьсгал ордог. Жилийн туршид салхитай өдрүүд зонхилдгоос хөрсний чийгшил маш муу, хуурайшилт ихтэй. Жилийн ихэнх өдрүүд нь цэлмэг нартай байдаг бөгөөд өвөл цас их унасан үед агаарын чийгшил 70-80% хүрэх ба зуны хамгийн чийглэг хур борооны үе 8-р сард ч агаарын чийглэг 40%-иас хэтрэхгүй.

Хур тунадасны дундаж уналт 180-210мм орчим бөгөөд, хамгийн их унах үе нь 7 сард 250 мм хүрдэг. Олон жилийн ажиглалтаас 10-р сарын 20-оос 11-р сарын 5-ны хооронд цасан бүрхүүл тогтож, энэ нь гуравдугаар сарыг дуустал үргэлжилнэ. Цасан бүрхүүлийн зузаан олон жилийн дунджаар 4-5 см зарим зудтай жил 25 см хүрэх нь бий. Агаарын даралт улирал бүрд харилцан адилгүй, жилийн дундаж даралт 1022-1034м/б, харин хаврын улиралд агаарын даралт тогтворгүй 20-12 м/б-аар багасах бөгөөд энэ нь салхи ихтэй чиглэл нь тогтворгүй болох нөхцлийг бүрдүүлнэ.

Усан сүлжээ

Нуурын болон гадаргуугийн усны тархалтын хувьд маш дутмаг. Төв азийн гадагш болон тогтмол урсгалгүй гол мөрний дүүрэгт (Мэнэнгийн ай сав) хамаарна. Төслийн талбайн хэмжээнд гол горхи байхгүй, хур тунадсаар тэжээгддэг давстай нуур тойрмууд байх ба хур бороо багатай жилүүдэд ширгэдэг. Хашаат цайдам, Баян-усны, Их халуун шавар, Бага халуун шаварт зэрэг нуурууд бий. Мөн эрдэсжилт ихтэй гар худгууд байдаг. Нутгийн иргэд, малчид гар болон гүний худгуудын усаар малаа усалж, ахуйн болон ундны хэрэгцээгээ хангадаг.

Хөрс, ургамал

Тал хээрийн бүсийн хүрэн, цайвар хүрэн хөрс зонхилно. Мөн Их бага халуун шаварт нуурын хөндий, Баян-Усны говь, Уртцагааны говь зэрэг газраар давсархаг сайрын хөрстэй. Энд хазаар өвс, бутуул, ерхөг согоовор, хиаг, таана, агь, шивээт хялгана зэрэг шим тэжээл сайтай өвс ургамал зонхилох тул бэлчээрийн чанарын хувьд илүү сайн. Энэ төрлийн хөрсөнд ургамалжилт нягт, өндөр ургасан байдаг тул хадлан бэлтгэхэд тохиромжтой. Баян-усны говь, Их бага халуун шаварт нуурын хөндий, Урт цагааны говь зэргээр бударгана, таана, харгана, хазаар өвс зонхилон ургана. Зуны улиралд аянга цахилгааны улмаас тал хээрийн түймэр гарах тохиолдол цөөнгүй бөгөөд хавар намрын хуурайшилттай үед тал хээрийн түймэр гарах эрсдэл их байдаг.

Амьтны аймаг

Орон нутгийн газарзүйн онцлог цаг уурын нөхцөл зэргийг харгалзан, Монгол Дагуурын ба Хойд говийн тойрогт хамааруулан үзэж болох юм. Монгол Дагуурын тойрогт гол төлөв үлийн цагаан огтоно, хэргэлзээт огтоно, үхэр огдой, зурам, шар сүүлт, чичүүл зэрэг мэрэгчид туурайтнаас цагаан зээр, араатнаас үен, өмхий хүрэн, хярс, үнэг, мануул, илбэнх, дорго, чоно амьдардаг. Хойд говийн тойрогт үхэр огдой, сүүлт чичүүл, улаан шанаат зурам, алаг даага, туурайтнаас цагаан зээр, араатнаас өмхий хүрэн, хярс, чоно голлон амьдарна. Жигүүртнээс тас, элээ, сар, хэрээ зэрэг махчин шувууд байхаас гадна янз бүрийн жижиг шувууд болон болжмор элбэг байдаг.

Эдийн засаг, хүн ам

Баянтүмэн сум нь дэд бүтэц сайн хөгжсөн аймгийн төв Чойбалсан хотын ойролцоо 12 км зайд байрладагаараа онцлог бөгөөд засаг захиргааны анхан шатны нэгж 4 багтай, 2085 хүн амтай, 82942 толгой малтай, төсвийн 5, хувийн хэвшлийн 11 байгууллага, 2 хоршоо, малчдын 23 бүлэг, 103 хүүхэд 26 багш ажиллагсадтай ерөнхий боловсролын сургуультай, соёлын төв, шуудан холбоо тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Тус сум нь 832080.0 га газар нутагтайгаас газар тариалан 7203.7 га, хөдөө аж ахуйн 739143.4га талбайг хамрана. Хөдөлмөрийн насны 1210 иргэнээс төрийн байгууллагад 165, хувиараа хөдөлмөр эрхлэгч 368 иргэн байна.

Дэд бүтэц

Сүүлийн жилүүдэд сумуудад улс, орон нутгийн хөрөнгө оруулалт төсөл хөтөлбөрийн хүрээнд бүтээн байгуулалтын ажлууд хийгдэн 24 цагийн эрчим хүч, интернэт, үүрэн телефоны сүлжээ нэвтэрсэн байна. Сумын хүн амын ихэнх нь халхууд болон цөөн тооны буриад, барга ястнууд амьдардаг. Хашаатын цав талбай нь сумын төвөөс зайтай, хилийн хоройтой бүсэд байрладаг учир хүн амын нягтрал маш сийрэг, Халх гол болон Сүмбэрийн төв замаас 10-15 км зайд байрлана.

Зам харилцаа

Улаанбаатар хотоос замын ихэнх хэсгийг хар замаар, болон нэвтрэлт сайтай шороон замаар явж хүрнэ. Харин Матад сумын төв хүртэл шулуун зам байхгүй. Сүмбэр сумын замаар хазайж 137 км явж хүрнэ. Матад сумын төвөөс Чойбалсан хот хүртэл 150 км орон нутгийн чанартай шороон замтай болно. Өндөр ургасан шивээ, өвс ургамлаар хучигдсан дош, довуудтай. Хуурайшилттай үед өндөр ургасан шивээн толгой, өвс ургамал нь автомашины мотор, яндаг зэрэгт хуримтлагдан улмаар шатах, хээрийн түймэр гарах тохиолдол цөөнгүй гардаг.

ГУРАВ. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

3.1. Уулын ажлын гүйцэтгэл:

“Хашаатын Цав” хүрэн нүүрсний ил уурхайн төслийн уул ашиглалтын байдал 2022 оны 11 сарын байдлаар нийт уулын цул 29,842,366 м³, нь 29,429,335 м³ нийт хөрс, 972,042 м³ шимт хөрс хуулсан байна.

Хүснэгт 2. Уурхайн үйл ажиллагаанд өртсөн талбайнууд

№	Хэмжээсүүд	Талбай, га	Эзлэхүүн
1.	Уурхайн олборлолтын талбай	80.0	29, 842, 366
2.	Хөрсний овоолго	149	29,429,335
3.	Зам талбай	29.6	-
4.	Шимт хөрс	16.0	972,042
5	Засварын талбай	30.0	-

Хүснэгт 3. Уурхайн уулын гүйцэтгэл

Уурхайгаас нийт гарсан уулын цулын задаргаа						
Он/сар		Хөрс (м3)	Шимт хөрс (м3)	Нүүрс		Нийт
				(м3)	тонн	
2022	1-р сар	2,840,238	51,904	-	-	2,892,142
	2-р сар	3,828,245	26,184	-	-	3,854,429
	3-р сар	2,620,486	92,885	-	-	2,713,371
	4-р сар	1,700,406	29,467	-	-	1,729,873
	5-р сар	2,912,680	77,209	-	-	2,989,889
	6-р сар	3,692,945	46,639	-	-	3,739,584
	7-р сар	3,843,636	31,676	-	-	3,875,312
	8-р сар	3,520,063	31,080	-	-	3,551,143
	9-р сар	2,629,062	25,987	-	-	2,655,049
	10-р сар	1,841,574	-	-	-	1,841,574
	11-р сар	-	-	-	-	-
	12-р сар	-	-	-	-	-
	Нийт	29,429,335	972,042	-	-	29, 842, 366

Уурхайн ажиллах горим:

Уурхайн үйл ажиллагаа нь тасралтгүй ажиллагаатай явагдах бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын хүндрэл, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалж болно. Хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Уурхайн 14 хоног ажиллаж, 14 хоног амрах үндсэн ээлжтэй байна.

3.2. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц

Ил уурхай:

“Хашаатын Цав” хүрэн нүүрсний ил уурхайн олборлолтын талбай 159.06 га Уурхайн хөрс хуулалт, “төслийн 11 сарын байдлаар нийт уулын цул 30,424,377 м³, нийт хөрс хуулалт нь 29,459,335 м³, 972,042 м³ шимт хөрс хуулсан байна.



Зураг 2. Ил уурхайн харагдах байдал
Уурхайн дотоод болон гадаргуугийн зам

Автозамын техникийн нөхцөл нь замын норм дүрмийн дагуу хоёр урсгалтай, замын зорчих өргөн тооцоогоор 18.5 м, сонгосон өргөн нь 20 м, замын дагуугийн хамгийн их налуу 120% байна. Хашаатын цав ордын цаашдын ашиглалтын хэтийн төлөв, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, ахуйн эрүүл таатай орчинг бий болгох зорилгоор үйлдвэрлэлийн, бусад замуудын тоосжилтыг дарж, замын арчилгааг байнгын хийж байна.



Зураг 3. Ил уурхай дотоод зам

“Хашаат цав”-ын хүрэн нүүрсний ордын дэд бүтэц болох уурхайн цахилгаан хангамж, ус хангамж, дулаан хангамж, хотхоны барилга болон зам, харилцаа холбооны барилга байгууламжтай байна.

Засварын газар:

Засварын газрыг ил уурхайн баруун хойд талд 1100 м зайд байрлана. Засварын талбай нь тоног төхөөрөмж эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд хурдан шуурхай засварын газарт хүргэхэд ойр байх давуу талтай. Засварын газрыг аюулгүй ажиллагааны дүрэм стандартын дагуу барьж тоноглоно. Засварын газрын талбай нь 1500м² бөгөөд ажлын байр, сэлбэг ба шатах тослох материалын агуулах, засвар үйлчилгээний граш, тоног төхөөрөмжийн зогсоолын талбай зэргээс бүрдэнэ.



Зураг 4. Ил уурхайн засварын газар

Замын ашиглалт, үйлчилгээ

Ил уурхайн дотоод тээврийн автозамыг байнга хянах ба засч тэгшлэх, тоос дарах зэрэг ажлууд хийгдэнэ. Зам засвар, ашиглалт, үйлчилгээний ажилд зам тэгшлэх, замын бартаа саадыг арилгах, замын эвдрэлийг засах, хальтиргаа гулгаа үүсэхээс хамгаалж зам дээр шороо цацах, замыг бороо болон шар усны үерээс хамгаалах зэрэг ажлууд орно. Замын засвар үйлчилгээ, ул талбайн цэвэрлэгээний ажлыг үйл ажиллагааны явцад байнга хийж гүйцэтгэнэ. Үүнд Shantui SD-16 бульдозер, LIUGONG CLG835 утгуурт ачигч, LIUGONG CLG414 автогрейдер ашиглах ба шаардлагатай тохиолдолд уурхайгаас нэмэлт тоног төхөөрөмж татан ажиллуулна.

Цахилгаан хангамж

Ил уурхай, засварын хэсэг болон бусад ашиглалтын туршид цахилгаан эрчим хүч хэрэглэх цахилгаан хэрэглэгчдийн цахилгаан ачаалал, тэдгээрийн цахилгаан эрчим хүчний зарцуулна. Уурхайн ашиглалтын үед цахилгааны үндсэн гурван хэрэглэгч байна. Үүнд:

1. Аж ахуйн хэсэг

2. Уурхайн хэсэг
3. Засварын хэсэг

ДҮЕГ500DSHS маркийн цахилгаан генераторыг Япон улсаас албан ёсны эрхтэйгээр “Юнитра” ХХК борлуулдаг бөгөөд 36.1 кВт-ын цахилгааны хэрэглээг хангах хүчин чадалтай юм. Уурхайн гэрэлтүүлэг, ажилчдын найдвартай ажиллагааг хангах үүднээс хөрөнгө оруулалт хэсэгт 2 ширхэг ба уурхайн ахуйн хэрэгцээнд 1 ширхэг генератор ашиглаж байна.



Зураг 5. Ил уурхайн цахилгааны үүсгүүр /цахилгаан генератор/
Уурхайн хотхон

Хашаатын цав уурхайд 1-10 сар хүртэл нийт 4н туслан гүйцэтгэгч компаниудын ажилчдын хотхонд нийт 621 хүн, 10 сарын-1 нээс эхлэн тухайн төсөлд 2 туслан гүйцэтгэгч болон тухайн төсөлд нийт 321 хүн ажиллаж амьдарч байна. Уурхайн ашиглалтын хугацаанд уурхайн оффис, ажилчдын байр, цайны газар, халуун усны газар, засварын газар, харуулын байр зэргийг урт хугацаанд ашиглагдах сэндвичэн хийцийн барилга байгууламжтай.



Зураг 6. Уурхайн ажилчдын хотхон
Уурхайн усан хангамж, усны хэрэглээ:

Уурхайн унд-ахуйн буюу технологийн усны хэрэглээг уурхайн лиценцийн талбайд өрөмдсөн 1 худаг, уурхайн кемп дээр гаргасан 2 гүний худгаас ханган ажиллаж байна. “Вертекс Майнинг Партнерс” ХХК-ний кемпийн ундны усны гүний худгийн

ундарга 2.0 л/сек, худгийн өрөмдлөгийн гүн 60 метр, уст давхарга нь 38 метр байна. Тус компани технологийн худаг худгийн ундарга 2.0 л/сек, худгийн өрөмдлөгийн гүн 120 метр, уст давхарга нь 97 метр, дундаж зузаан нь 90 метр байна.

“Меланж” ХХК-ний кемпийн ундны усны гүний худгийн ундарга 2.0 л/сек, худгийн өрөмдлөгийн гүн 98 метр, уст давхарга нь 38 метр, дундаж зузаан нь 34 метр байна.



Зураг 7. Хашаатын цав уурхайн технологийн болон ундны усны гүний худгууд

3.3.Төсөлтэй холбогдох тусгай зөвшөөрөл, гэрчилгээ

Хүснэгт 4. Ашигт малтмалын ашиглалтын эзэмшдэг тусгай зөвшөөрлүүд

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Дугаар	Хүчинтэй хугацаа
1	Хашаат цав	MV-020936	2047.09.29

Хүснэгт 5. Хашаатын цав уурхайн газар ашиглах зөвшөөрөл авахаар өгсөн газрын жагсаалт

№	Газар эзэмших зориулалт	Гэрчилгээний дугаар	Газрын хэмжээ /га/	Хүчинтэй хугацаа
1	Технологийн зам	-	16.5	-
2	Хогийн цэг	-	0.25	-
3	Нүүрс тээврийн зам	-	8.0	-
4	Хөрсний овоолго	-	218.5	-
5	Ил уурхай	-	120.5	-
6	Гаалийн хяналтын бүс	-	8.3	-
7	Засварын газар	-	4.0	-
8	Шимт хөрсний овоолго	-	47.5	-
9	ШТС	-	1.0	-
10	Уурхайн хотхон	-	36.61	-
11	Нүүрс буулгах талбай	-	8.46	-
12	Юнител	-	0.7	-
13	Усан сан	-	7.6	-
14	Түр засварын талбай	-	10.6	-

“Меланж”ХХК нь Хашаатын цавын хүрэн нүүрсний ил уурхайн Байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг (БОННУ) 2021.10.21-нд “Экотайкүүн”ХХК мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа БОННУ-ний тайлангуудыг доорхи хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 6. Хүчин төгөлдөр уурхайн БОННУ-тайлангууд

№	БОННУ-ний тайлангийн нэр	Батлагдсан он
1	Дорнод аймаг Баянтүмэн суманд хэрэгжих “Хашаат цав нэртэй хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах” төслийн БОННУ	2021.11.сар
2	2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2022.04.07

3.4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн бүтэц

Хашаатын цав уурхайн МУ-020936 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж байгаа үндсэн олборлолтын үйл ажиллагаанаас тэдгээрийн БОННУ-үүдийг холбогдох хууль, журмын дагуу Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам баталсан.

Хашаатын цав нүүрсний уурхайн 2022 оны Байгаль орчны Менежментийн Төлөвлөгөөний Биелэлтийн Тайлан нь үндсэн олборлох үйл ажиллагааны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг нэгтгэсэн болно.

ДӨРӨВ. ТӨСЛИЙН ГОЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОВЧ

4.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, бууруулах арга хэмжээ

УУР АМЬСГАЛ	
<p>Төслийн үйл ажиллагаанаас уур амьсгалд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хур тунадастай өдрийн тоо нэмэгдсэнээр олборлолтын үйл явц саатах ✓ Аадар болон аянга цахилгаантай өдрийн тоо нэмэгдсэнээр техник тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа зогсолтод хүрэх ✓ Үер урсцын нөлөөгөөр төслийн талбайд их хэмжээгээр ус орсноор уурхайлалт түр зогсох 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн талбайд техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг маш сайн хангаж ажиллах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хорих шаардлагатай ✓ Техник хэрэгслийг талбайд гаргаж ажиллуулахгүй байх ✓ Зам, талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засаж бэлдэх
АГААРЫН ЧАНАР	
<p>Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног, төхөөрөмжийг тээвэрлэх, суурилах явцад тоосжилт ихээр үүсэх; ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх; 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэхээс сэргийлж зам талбайн усалгааг сайтар хийх;
УСАН ОРЧИН	
<p>Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглах усны хэмжээгээр газрын доорх усны нөөц багасах; ✓ Ахуйн бохир усыг ил задгай хаяснаар хөрсний ус бохирдох; ✓ Ариун цэврийн байгууламж, хог хаягдлын цэгийг стандартын дагуу байгуулаагүйн улмаас хөрсөнд нэвчилт үүсэх, ул хөрсний усыг бохирдуулах; 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн үйл ажиллагаанд ашиглах боломжит усны нөөцөөс хэтрүүлэхгүй байх; ✓ Ахуйн шингэн хаягдлыг ил задгай асгахгүй байх, зориулалтын цэгт хаяж байх; ✓ Ариун цэврийн байгууламж, хог хаягдлын цэгийг стандартын дагуу хийж гүйцэтгэх;
ГАЗРЫН ГАДАРГА БОЛОН ХӨРСӨН БҮРХЭВЧ	
<p>Төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p>	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн барилга байгууламж баригдаж эхлэхээс өмнө сайжруулсан

<ul style="list-style-type: none"> ✓ Хатуу хучилттай зам барих хүртэл газрын гадарга эвдрэлд өртөх болон хөрсөн бүрхэвч доройтох; ✓ Барилга байгууламжийн нөлөөгөөр газрын хэвлий болон хөрсөн бүрхэвч чанараа алдах; ✓ Төслийн дотоод зам, талбай болон гадна талбайд олон салаа зам гаргахгүй байх; ✓ Уурхайлалтаар хөрсний морфологи болон физик шинж чанар алдагдаж хөрсний үржил шим буурах, ойр орчмын талбайн хөрс доройтолд өртөх; ✓ Эрүүл талбайн өнгөн хөрс овоолгод дарагдах, хөрсний гадарга дээр нарийн ширхэгт тоосны хучаас үе үүсэх; ✓ Хөрсний элэгдэл эвдрэл үүсгэснээр байгалийн ус салхины эвдрэлийг эрчимжүүлж хөрс салхинд хийсэх болон гадаргын урсцаар угаагдаж элэгдэх; ✓ Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах; 	<p>шороон замыг ашиглалтад оруулах, төслийн үйл ажиллагаа эхлэхэд хатуу хучилттай автозамыг ашиглалтад оруулах;</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн талбайд маршрут гарган бусад хэсгээр тээврийн хэрэгслийг зорчуулахгүй байх; ✓ Тээврийн хэрэгслийн зогсоол, ногоон байгууламжийг зөв оновчтой төлөвлөх; ✓ Үржил шимт хөрсний овоолгыг стандартын дагуу тогтмол усалж, шинж чанарыг хамгаалж, тордож байх
<p>УРГАМАЛЫН НӨМРӨГ</p>	
<p>Төслийн үйл ажиллагаанаас ургамлын нөмрөгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн барилга байгууламж, уурхайлалтын хэмжээгээр ургамлын нөмрөг бүрэн устах; ✓ Төслийн талбайд автотээврийн хэрэгсэл, хүний үйл ажиллагааны улмаас ургамал ургаж буй хэсгийг талхагдалд оруулах шиглагдаж буй тээврийн хэрэгслүүдээс нефтийн бүтээгдэхүүн алдагдаж, ургамлын нөмрөгийг гэмтээх, бохирдуулах; 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн талбайд ногоон байгууламжийг оновчтой төлөвлөх; } Хог хаягдлыг тогтсон нэг цэгт байршуулах; ✓ Түлш, шатах тослох материалыг ашиглаж буй орчинд тэдгээрийг нэвтэрч шүүрүүлэхгүй байх арга хэмжээг авч ажиллах ✓ Машин механизм, тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол, засвар үйлчилгээний зориулалтын талбай

	гарган орчны ургамлын талхлагдахаас сэргийлэх;
АМЬТНЫ АЙМАГ	
<p>Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Дуу чимээний нөлөөгөөр ан амьтад дайжих, амьдрах орчин нь өөрчлөгдөх; ✓ Тоосжилтоос мал, амьтанд сөргөөр нөлөөлөх; ✓ Олборлолт хийсэн нүхийг хашаалахгүйн улмаас мал, амьтан унах ✓ Цагаан зээр, хар сүүлтийн амьдрах орчинд нөлөөлөх 	<p>Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга, хэмжээний зөвлөмж: \</p> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийн лицензийн талбайн хязгаарыг хэтрүүлэхгүй байх; ✓ Үйл ажиллагааны явцад улирлаар нүүдэллэн ирдэг амьтдын байрших гол газар, коридор нутагт тэдгээр амьтдыг хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар орон нутгийн болон холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах, туслалцаа үзүүлэх; ✓ Амьтны аймгийг хамгаалахын тулд судалгаа шинжилгээ, сургалт сурталчилгаа, хяналт шалгалтын олон талт арга хэмжээг орон нутгийн холбогдох байгууллагууд, иргэдтэй хамтран цогцоор хэрэгжүүлэх; ✓ Хууль бус ан хийгчдийн үйл ажиллагааг таслан зогсоох, хууль бусаар ан агнуур хийхгүй байх талаар ажиллагсад болон нутгийн иргэдэд тогтмол сургалт сурталчилгаа хийж байх;
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ	
<p>Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Шинээр ажлын байр бий болох; ✓ Улс, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх; ✓ Татварын орлого өсөх; 	

ТАВ. ТӨСЛӨӨС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

“Хашаатын Цав” төслийн үйл ажиллагааны явцад буюу хөрс хуулалт, нүүрс олборлох тээвэрлэх үйл ажиллагаа болон уурхайн хаягдлын овоолгуудаас их хэмжээний тоос, тооцонцор үүсэх боломжтой бөгөөд энэ нь агаар бохирдуулагч гол хүчин зүйл болдог. Мөн уурхайн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа, дизель генераторууд, тээврийн хэрэгслүүдээс агаар бохирдуулагчид ялгарч орчныг бохирдуулах магадлалтай юм. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах 5 үндсэн чиглэлийн хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөж тухайн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.


Хүснэгт 7. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Биелэлт, тайлбар
Хашаатын цавын хүрэн нүүрсний уурхайг ил аргаар ашиглах явцад уурхайгаас жилд дунджаар 2861.8 тн тоосжилт үүсэхээр байна.	<ul style="list-style-type: none"> Хашаатын цавын уурхайн талбайд тоосны тархалтын загварчлал хийх Ил уурхайд тоосжилтыг бууруулах туршилтаар мананжуулагч систем суурилуулж, тоосжилтын эх үүсвэрийг чийгшүүлэх 	Хашаатын цавын хүрэн нүүрсний уурхайг ил аргаар ашиглах явцад уурхайн тоосжилт их бага хэмжээгээр үүсч байгаа тул уурхайн усалгааны ажлыг уурхай эхсэнээс хойш 11 сарын 1 хүртэл тасралтгүй хийж гүйцэтгэсэн байна. Уурхайн тоосжилтонд ашиглаж байгаа гүний худгийн байршил, одоогийн нөхцөлд мананжуулагч байршуулах боломжгүй байсан учраас усалгааг тогтмол гүйцэтгэхэд анхаарч гүйцэтгэгч компани бүр 2 усалгааны машинтай усалгааг тогтмол хийж гүйцэтгэн ажиллаж байна.
Дизель станцын яндангийн утаан дахь хийн агууламж стандарт агууламжаас давах	<ul style="list-style-type: none"> Хорт хийн ялгарлыг бууруулахын тулд дизель станцад хэрэглэх түлшийг хорт хий шингээдэг кальцийн карбонат зэрэг бодистой хамт хэрэглэх Янданд утаа шүүгч суурилуулах 	Хашаатын цав уурхайд зөөврийн цахилгаан зөөврийн генератор ажиллах цахилгааны эх үүсвэрийг хангадаг. Тухайн дизель станцын засвар үйлчилгээг тогтмол хийж агаар, утаа шүүгчийн сольж ашигладаг болно. Уурхайн кемпэд хийсэн агаар дахь хорт хийнүүдийн агууламжийг хэмжихэд стандарт түвшингээс бага буюу хэвийн байна.
Нүүрсний агуулах дахь нүүрсний овоолгуудыг удаан хугацаагаар хадгалах явцад нүүрс өөрөө халж, ноцох үзэгдэл гарч болзошгүй	<ul style="list-style-type: none"> Нүүрсний өөрөө ноцоолтыг хянах, нүүрс шатаж болзошгүй газруудад дулаан мэдрэгчтэй камер суурилуулах зэргээр хяналтыг тавих 	Хашаатын цав уурхайн одоогийн байдлаар нүүрсний агуулах баригдах талбай бэлтгэх, тухайн талбайн хөрс хуулах бэлтгэл ажлууд одоогоор хийгдэж байна. Энэ жил тухайн ажлыг гүйцэтгэх боломжгүй нүүрс гарч эхлээгүй байна. Цаашид нүүрсний агуулах баригдсаны дараа тухайн ажлыг гүйцэтгэх бүрэн боломжтой болно.

<p>Уурхайн шороон болон сайжруулсан дотоод замуудаас тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэж агаарыг бохирдуулах</p>	<ul style="list-style-type: none"> • Зорчих хэсгийн шороон замыг хайргаар хучих, цаашид хатуу хучилттай болгох, үйл ажиллагааны туршид арчлах • Дулааны улирлын халуун, хуурайшилт ихтэй үед шороон замыг тоос дарагч бодис бүхий усаар усан чийгшүүлэх • Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг тухайн замын онцлогт тохируулан хязгаарыг тогтоож мөрдүүлэх 	<p>Уурхайн бүх чиглэлийн технологийн замуудад давхар хөрсний дэвсэлт 30-50 см зузаан хийгдсэн. Технологийн замын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт бууруулахаар тогтмол арчилгаа усалгаа хийгдсэн байна. Уурхайн тээврийн хэрэгслүүд уурхай дотроо дагаж мөрдөх хурдны тусгай журам тогтоон түүний дагуу хурдны хязгаарыг мөрдөн ажиллаж байна. Уурхайн олборлолтын технологийн зам 40 км/цаг, уурхайн налуу замд 30 км/цаг, хөрсний овоолгод 40 км/цаг, засварын төвд 20 км/цаг, кемпээс уурхай орох замд 50 км/цаг хурдны хязгаарыг тус тус дагаж мөрдөн уурхайн хөдөлгөөнд оролцдог болно.</p>
<p>Төслийн талбайд ажиллаж буй тээврийн хэрэгслүүдийн яндангаас агаар бохирдуулагч хий цацагдаж, агаар орчныг бохирдуулах</p>	<ul style="list-style-type: none"> • Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг хангах 	<p>Төслийн талбайд ажиллаж буй тээврийн хэрэгслүүдэд “Меланж” ХХК дотоод журмын дагуу 7 хоног тутамд техникийн үзлэг тогтмол хийгдэж байна. Уурхайн хяналт шинжилгээний үр дүнгээр ямар нэгэн хортой хийн агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй болно.</p>

1. Хашаатын цавын уурхайн талбайд тоосны тархалтын загварчлал хийх

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь салхи шуурга ихтэй Монгол орны тал хээрийн бүсэд байрлах тул уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын Загварын тооцооллын үр дүнгээр төслийн энэ жилийн тархалтын зургийг хийлгэсэн болно. Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт төслийн эхний жилд орчны агаар дахь PM10 тоосонцрын хоногийн дундаж агууламжийг хамгийн ихдээ 2987 мкг/м³ хүртэлх хэмжээгээр нэмэгдүүлэхээр байна. Уурхайн карьер, хөрсний овоолго, тээврийн орчим тоосны агууламж ерөнхийдөө их байх ба уурхайгаас бүх чиглэлд, өмнө зүгт хамгийн холдоо 13 км хүртэлх газарт агаар дахь PM10 тоосонцрын хоногийн дундаж агууламжийг 50 мкг/м³-р нэмэгдүүлж байна.



2. Ил уурхайд тоосжилтыг бууруулах, тоосжилтын эх үүсвэрийг бууруулах усалгаа хийх

Хашаатын цавын хүрэн нүүрсний уурхайг ил аргаар ашиглах явцад уурхайн тоосжилт их бага хэмжээгээр үүсэх тул уурхайн усалгааны ажлыг 3 сарын 1-н нэгээс эхлүүлэн 11 сарын 1 хүртэл тасралтгүй хийж гүйцэтгэж байна. Уурхайн тоосжилтод ашиглаж байгаа гүний худаг, зуны улиралд хур борооны ус, уурхайн шүүрлийн ус тогтмол ашигласан байна. Уурхайн хөрс хуулалтын ажил гүйцэтгэгч компани бүр 2 усалгааны машинтай, тоосжилтыг бууруулах усалгааг тогтмол хийж гүйцэтгэсэн болно. Уурхайн тоосжилтыг бууруулах өдөр тутам усалгааг өдөр, шөнийн үед тогтмол усалгаа хийж ажилласан болно.





Зураг 8. Уурхайн дотоод зам талбайн усалгаа хийгдсэний дараа

Уурхайн зам талбайн тоосжилтыг бууруулах усалгаанд 3-6 сарын байдлаар уурхайн технологийн зориулалтын 2 гүний худгаас 29159 м³, 7-8 саруудад худгийн уснаас гадна хур борооны 11740 м³ усыг хуримтлуулах байдлаар усалгаанд давхар ашигласан бол 9-11 сарын хугацаанд уурхайн шүүрлийн уснаас 17455м³ зам талбайн усалгааны зориулалтаар тус тус ашигласан байна.



Зураг 9. Технологийн худаг №01



Зураг 10. Технологийн худаг №02



Зураг 11. Уурхайн шүүрлийн усыг тусгай зумп байгуулж хуримтлуулан ашигласан байдал



Зураг 12. Хур борооны хуримтлуулагдсан усыг соруулж усалгаанд ашигласан байдал
Хашаатын цавын хүрэн нүүрсний ил уурхайн хөрс хуулалтын ажил 2021 оны 12 сараас эхэлсэн бөгөд уурхайн дотоод тээвэрлэлт, тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөн нь агаарт тоосжилт үүсгэх гол эх үүсвэр юм. Уурхайн тоосжилтыг бууруулах зорилгоор хөрс хуулалтын ажлыг эхэлснээс 2022.03.01-2022.10.31 хүртэлх 11 сарын байдлаар гүний худгийн уснаас 29159 м³ ус ашигласан байна.

Хүснэгт 8. Уурхайн технологийн худгаас 1-10 сард усалгаанд ашигласан усны
ХЭМЖЭЭ

Сар	Худгийн нэр	Эхэлсэн тоолуурын заалт, м ³	Дууссан тоолуурын заалт, м ³	Тухайн сар ашигласан ус, м ³	Гүний худгаас усалгаанд ашигласан ус, м ³
01 сар	Технологи №01	--	-	-	-
02 сар	Технологи №01	-	-	-	-
03 сар	Технологи №01	00000	1137	1137	1137
	Технологи №02	-	-		
04 сар	Технологи №01	3576	3576	3576	4350
	Технологи №02	774	774	774	
05 сар	Технологи №01	3576	5562	1986	6230
	Технологи №02	774	4992	4218	
06 сар	Технологи №01	5562	7622	2060	5847
	Технологи №02	4992	8779	3787	
07 сар	Технологи №01	7622	7858	236	3258
	Технологи №02	8779	11801	3022	
08 сар	Технологи №01	7858	0	0	3668
	Технологи №02	11801	15469	3668	
09 сар	Технологи №01	7858	0	0	3332
	Технологи №02	15469	18801	3332	
10 сар	Технологи №01	7858	0	0	2500
	Технологи №02	18801	21301	2500	




График 1. Хашаатын цав уурхайн тоосжилтонд ашигласан гүний худгийн ус




График 2. Хашаатын цав уурхайн тоосжилтонд ашигласан хур тунадасны болон шүүрлийн ус

3. Дизель станцын яндангаас ялгарч буй утааны найрлагыг хянах

Хашаатын цав уурхайн цахилгаан хангамжийн бага оврын зөөврийн цахилгаан генератор ашигладаг бөгөөд тухайн цахилгаан генераторын засвар үйлчилгээ хийгдэх үед агаар шүүгчийн тогтмол сольж ажилладаг. Уурхайн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу уурхайн кемп болон бусад хяналтын цэгүүдэд хортой хийн агууламж илрээгүй болно.

4. Зорчих хэсгийн шороон замыг хайргаар хучих, цаашид хатуу хучилттай болгох, үйл ажиллагааны туршид арчлах дулааны улирлын хуурайшилт ихтэй үед шороон замыг тоос усаар усан чийгшүүлэх

Уурхайн дотоод бүх замыг давхар дэвсэлт хийж хучилт хийгдсэн, тухайн дотоод замыг усалгаа хийж, тухайн замуудад мөрдөх хурдны тодорхой хязгаарыг тогтоон түүнийг баримтлан ажилладаг.



Зураг 13. Уурхайн хотхоноос уурхай орох замын хайрган дэвсэлт хийгдсэн байдал



Зураг 14. Уурхайн дотоод тээврийн замд дэвсэлт болон усалгаа хийгдсэн байдал

5. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг тухайн замын онцлогт тохируулан хязгаарыг тогтоож мөрдүүлэх

Хашаатын цав уурхайн дотоод замын хөдөлгөөнийг зохицуулах, дагаж мөрдөх журмын дагуу хөдөлгөөний хурдыг зохицуулдаг болно.



Зураг 15. Уурхайн дотоод тээврийн хөдөлгөөний хурдны хязгаар

6. Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг хангах

Хашаатын цав уурхайн туслан гүйцэтгэгч “Вертекс Майнинг Партнер” ХХК, “Эм Вай Си” ХХК, “Хишиг Арвин” ХХК, “Талын ат” ХХК нийт 4-н компаниуд тухайн

уулын ажил, хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж байгаа тул тухайн компаниуд дотоод журмын дагуу техникийн үзлэг тогтмол хийж, хяналт, шалгалт хийж ажилладаг болно.

6.2.Газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Төслөөс газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэлтэй газрын эвдрэл, мөн техник хэрэгсэл, тээврийн нөлөөгөөр газрын бүрхэвч элэгдэх, олон салаа зам гарч доройтох нөлөөгөөр их хэмжээгээр газрын эвдрэл үүсэх, тоосжилтоор, хөрс дарагдах хучигдах газрын гадаргын ухаш үүсэх, газрын эвдрэл нөлөөллүүд болж байна. Хашаатын цав уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр 2022 оны 11 сарын байдлаар уурхайн карьер олборлолтын үйл ажиллагаанд 80.0 га, хөрсний овоолго 149 га, засвар үйлчилгээний талбай 30 га, шимт хөрсний овоолго 16.0 га, зам 29.6 га газрын эвдрэлд орсон байна. 2022 оны БОМТ-нд газрын газрын хэвлий, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах нийт 4 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг дараах хүснэгтэд харуулсан болно.

Хүснэгт 9. Газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл

Болзошгүй нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэрэгжүүлсэн ажил
Ил уурхайгаас хуулсан хөрсийг 294.6 га талбайд Хаягдал чулуулгийн овоолго үүсгэн газрын гадаргын төрхийг өөрчлөх	Овоолгын ерөнхий налууг 22о байхаар тооцож гадаргууг тогтворжуулах	Уурхайн хөрсний овоолгын налууг 22о байхаар төлөвлөн хөрсний овоолго үүсгэн хадгалж байна
Хаягдал чулуулгийн овоолгоос хүчиллэг урсац үүсэж газрын гадарга хэвлийг бохирдуулах	Хаягдал чулуулгийн овоолго, бусад хүчиллэг урсац үүсэж болзошгүй газруудад чулуулгаас дээж авч хүчиллэг урсац үүсгэдэг эрсдэлүүдийн судалгааг хийж, гарах үр дүнтэй уялдуулан хүчил үүсгэх чулуулгийг саармагжуулах зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Уулын олборлолтын үйл ажиллагааны тухайн талбайн хөрсний бүтцээс шалтгаалан одоогийн байдлаар хүчиллэг тунадас үүсээгүй болно.
Уурхайн тосгон, уурхайн оффисоос гарсан хатуу, шингэн хог хаягдлаар газрын гадарга, хэвлийг бохирдуулах	Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдлыг зориулалтын нэгдсэн цэгт цуглуулж, зайлуулах Ахуйн шингэн хаягдлыг бага оврын цэвэрлэх байгууламж ашиглан шийдвэрлэх	Уурхайн гүйцэтгэгч компани бүр хог хаягдлын тусгай цэгт ахуйн хаяг хаягдлыг түр хугацаагаар хадгалж гэрээний дагуу Баянтүмэн сумын нэгдсэн хогийн цэгт хүргүүлэн нийлүүлэн ажиллаж байна.
		-

Овоолгын ерөнхий налууг 22о байхаар тооцож гадаргууг тогтворжуулах

Ил уурхайгаас хуулсан хөрсийг хөрсний чулуулгийн овоолго үүсгэж, уурхайн хөрсний овоолгын налууг 35-37 градус байхаар төлөвлөн одоогийн байдлаар 149.0 га талбайд 30,424,377м³ хөрсний овоолго үүсгэн хадгалж байна.



Зураг 16. Уурхайн хөрсний гадаад овоолго

1. Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдлыг зориулалтын нэгдсэн цэгт цуглуулж, зайлуулах


Уурхайн ажилчдын хотхоноос үүсэх ахуйн хог хаягдлыг тусгай хогийн цэгт түр хугацаагаар хуримтлуулан хадгалж, ахуйн хаяг хаягдлыг гэрээний дагуу Дорнод аймгийн Баянтүмэн суманд нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн хүргүүлдэг.



Зураг 17. Уурхайн хотхоны ахуйн хог хаягдлын цэг



Зураг 18. Уурхайн хотхоны ахуйн хог хаягдлыг ачуулсан байдал



Зураг 19. Уурхайн хотхоны ахуйн хог хаягдлын ангилан ялгах сав

2. Ахуйн шингэн хаягдлыг бага оврын цэвэрлэх байгууламж ашиглан шийдвэрлэх

Хашаатын Цав уурхайн ажилчдын кемпийн үйлчилгээнд ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж барих судалгаа хийж холбогдох газруудаас үнийн судалгаа авч байсан энэ жилийн хувьд тухайн ажлыг санхүүгээс шалтгаалж шийдвэрлэх боломжгүй болсон. Одоогоор 3-н туслан гүйцэтгэгч компаний ахуйн бохир усыг тусгайлан хуримтлуулан соруулахаар зохион байгуулсан. Тухайн компани бүр кемпэд 40-60 тн сав суурилуулж тухайн саванд бохироо хуримтлуулан соруулж байна. Дорнод аймгийн нийтийн аж ахуйн газартай Бохир ус нийлүүлэх гэрээний дагуу ахуйн бохир усыг тогтмол соруулж байна. Уурхайн ахуйн бохир ус нийлүүлэх гэрээг Дорнод аймгийн НАА-д газарт хийсэн хамтран ажиллаж байна.

“Вертекс Майннинг Партнер” ХХК Кемпийн усан хангамж гүний худгаас хуримтлуулах саванд 15 тн ёмкост хүлээн авч гном насосоор халуун, хүйтэн 70 м урт усны шугамаар гал тогоо болон халуун усны газрыг усаар хангана. Бохир хуримтлуулах 60 тн сав далд суурилуулсан.



Зураг 20. “Вертекс Майнинг Партнер” ХХК-ний Кемпийн бохир усны худаг “Хишиг Арвин Индустриал” ХХК-н кемпийн нийт 150 орчим хүн ажиллаж амьдардаг. Кемпийн усан хангамж гүний худгаас зөөвөрлөж 10 тн ёмкост хуримтлуулах саванд хүлээн авч гном насосоор 5м-н урт усны шугамаар гал тогоо болон халуун усны газрыг усаар хангана. Бохирын ёмкось 60 тонн багтаамжтай сав далд суурилуулсан байна.









Зураг 21. “Хишиг Арвин Индустриал” ХХК-н кемпийн бохир усны сав “Эм Вай Си” ХХК Кемпийн нийт 120 орчим хүн ажиллаж амьдардаг. Кемпийн усан хангамж гүний худгаас зөөвөрлөдөг 1тн ёмкоьт хуримтлуулах саванд хүлээн авч гном насосоор 5м-н урт усны шугамаар гал тогоо болон халуун усны газрыг усаар хангана. Бохирын ёмкост 40 тонны багтаамжтай.

“Талын ат” ХХК Кемпийн нийт 65 хүн ажиллаж амьдардаг. Кемпийн усан хангамж гүний худгаас зөөвөрлөдөг 1 тн ёмкоьт хуримтлуулах саванд хүлээн авч гном насосоор 5м-н урт усны шугамаар гал тогоо болон халуун усны газрыг усаар хангана. Бохир цэвэрлэх Юнинос маркийн 98 хувийн цэвэрлэх байгууламжтай. кэмпийн гал тогоо, душ, ариун цэврийн байгууламжийг шинээр барьж ахуйн бохир шингэн хаягдлыг цэвэрлэх бага оврын Юнинос маркын бохир цэвэрршүүлэгч төхөөрөмжийг суурилуулсан. Ингэснээр бохирыг байгальд шууд нийлүүлэхгүйгээр шүүж саарал ус болгон дахин ашиглах юм.





Зураг 22. Ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламж /далд /

<p>   </p> <p align="center">БОХИР УС НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ</p> <p>2022 оны 04 сарын 14 өдөр № 01 Чойбалсан хот</p> <p>Нэг талаас "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНВААТУГ-ын Ариутгах татуургын албаны техникч С.Батбаяр Лавшид: "Гүйцэтгэгч" гэх, нөгөө талаас "ВАЙТ ГРУПП" ХХК-ийг төлөөлж Менежер Д.Хандсүрэн Лавшид: "Захиалагч" гэх бид харилцан тохиролцож, энэхүү гэрээг доорх нөхцөлөөр байгуулав.</p> <p align="center">Нэг. Ерөнхий зүйл</p> <p>1.1 Гүйцэтгэгч, захиалагчийн хүсэлтийн дагуу бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлэхээр энэхүү гэрээгээр тохиролцон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, зохицуулна.</p> <p>1.2 Энэхүү гэрээ нь хоёр талын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дэран баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.</p> <p align="center">Хоёр. Гэрээний зүйл, хугацаа</p> <p>2.1 Гүйцэтгэгч нь захиалагчийн хүсэлтийн дагуу автомашинаар зөөвөрлөгдөх бохир усны сүлд 2 удаа Ариутгах татуургын төв станцын арван КК-1 худалт нийлүүлэх бөгөөд замын хуудсаар баталгаажуулав.</p> <p>2.2 Гэрээг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.</p> <p>2.3 Гэрээг цуцлах тохиолдолд санал гаргаж буй тал нь нөгөө талд эхлэн 15 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.</p> <p align="center">Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг</p> <p>3.1 Гүйцэтгэгч нь төвлөрсөн ариутгах татуургын шугам сүлжээнд нийлүүлэх 1м3 бохир усны төлбөрийг 2700 /хоёр мянга долоон зуун/ төгрөгөөр тосцох бөгөөд төлбөрийг сар бүрийн 25-ны дотор нэхэмжлэхээр өгнө.</p>	<p>3.2 Гүйцэтгэгч нь төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлж буй бохир усанд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн эсэхэд хяналт тавьж, баталгаажуулан авах эрхтэй.</p> <p>3.3 Захиалагч нь төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд бохир усыг хүлээн авахгүй байх эрхтэй.</p> <p align="center">Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг</p> <p>4.1 Ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээнд бохир усыг гүйцэтгэгчид мэдэгдэж, замын хуудсанд тэмдэглэл хөтлөлт хийлгүүлнэ.</p> <p>4.2 Бохир усыг зөөвөрлөн нийлүүлэх автомашин нь техникийн аюулгүй ажиллагааг мөрдөж, нийлүүлэхээр тохиролцсон цэгт нийлүүлнэ.</p> <p>4.3 Ариутгах татуургын шугам сүлжээнд нийлүүлж буй бохир усанд ариутгал халдваргүйжүүлэлт хийх шаардлагатай.</p> <p>4.4 Захиалагч нь төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлэх бохир усны төлбөрийг Гүйцэтгэгчийн дансанд Хаван банкны 5405085220 дансанд шилжүүлсэн байна.</p> <p align="center">Тав. Бусад зүйл</p> <p>4.1 Гэрээг 2 хуви үйлдэх бөгөөд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.</p> <p>4.2 Энэ гэрээнд заагаагүй асуудлыг шийдвэрлэхдээ талууд Монгол улсын Иргэний хууль, тогтоомжийг удирдлага болгоно.</p> <p>4.3 Гэрээний хэрэгжилтийн явцад гарсан маргааныг талууд харилцан тохиролцох ба тохиролцох боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд Шүүхээр шийдвэрлүүлнэ.</p> <p align="center">Тав. Гэрээ байгуулсан талууд</p> <p>Гүйцэтгэгч: "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНВААТУГ-ын АТА-ны техникч  С.Батбаяр Утас: 85679883</p> <p>Захиалагч: "Титан хас Фүүд" ХХК-ийн менежер  Б.Очирбат Утас: 99119355</p>
--	--

Зураг 23. Дорнод аймгийн нийтийн аж ахуйн газартай байгуулсан бохир ус соруулах гэрээ

6.3. Гадаргын ус, газрын доорхи усны чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хашаатын цав уурхайн усны менежментийн хүрээнд уурхайн бүх үйл ажиллагаанд усыг зөв зохистой хэрэглэх, усыг дахин ашиглах, мөн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн усны нөөц, чанарт учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах байгаль дахь усны нөөц, чанарыг алдагдуулахгүй байхаар ажиллаж байна.

Хашаатын цавын уурхайн усан хангамжийн үндсэн эх үүсвэр нь гүний худаг буюу газрын доорх ус юм. Усны тухай хуулийн 28.2-т заасанчлан 2022 оны ус ашиглуулах дүгнэлтийг “Усны Газар” ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлагаас тухайн жилийн ус ашиглах төлөвлөгөөнд дээр үндэслэн ус ашиглах хэмжээг зориулалт тус бүрээр тооцоолон ус ашиглах дүгнэлтийн дагуу ашиглалт явуулж байна. 2022 оны БОМТ-нд гадаргын болон гүний усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах 4-н арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийг дараах хүснэгт -д товч байдлаар дурдав.


Хүснэгт 10. Гадаргын ус, газрын доорхи усны чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Болзошгүй нөлөөлөл	Газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Биелэлт
<i>Гадаргын ус</i>		
Хашаатын цавын хүрэн нүүрсний уурхайгаас баруун хойд зүгт 25км орчимд Хэрлэн гол урсана. Ордыг ашиглах явцад ил уурхайн ухаш, хаягдал чулуулгийн гадаад овоолгоос хүчиллэг урсац үүсэх, их хэмжээний аадар бороо, үерийн улмаас угагдлаа үүсэн гадаргын усыг бохирдуулах	Уурхайн хөрс, чулуулгийн овоолго, ухаш, нүүрсний овоолго зэрэг хүчиллэг урсац үүсэж болзошгүй хэсгүүдийн гадна талаар суваг, шуудуу татах, далан хаалт сэтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч байх, цаг уурын урьдчилсан мэдээ мэдээллийг тогтмол авч болзошгүй аюул эрсдэлийн үед бэлэн байх	Хашаатын цавын хүрэн нүүрсний уурхайгаас баруун хойд зүгт 25 км орчимд Хэрлэн гол урсана. Уурхайн ашиглах явцад их хэмжээний аадар бороо, үер буух үзэгдэл одоогоор тохиолоогүй ч уурхайд гадаргын ил задгай гол горхи, нуур ойрхон гадаргын усан сүлжээ бага болно. Төслийн талбайн онцлогоос шалтгаалж гадаргын усанд нөлөөлөх хэмжээнд нөхцөл байдал үүсэхгүй болно.
Уурхайн үйл ажиллагааны үед техник хэрэгслийн засварын газар, ШТС зэргээс ШТМ газрын хөрсөнд алдагдах, улмаар хур борооны усаар угагдан газрын хэвлийд шингэн газрын доорх болон гадаргын усыг бохирдуулах болзошгүй	Уурхайн дэвсгэр дэх ШТС, Засварын газар, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон уурхайн хүнд машин техник, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах Хуурай сайр, голдирлын ойролцоо автомашин, техник хэрэгслүүдийг шатахуунаар цэнэглэхгүй байх	Уурхайн нутаг дэвсгэр ШТС, Засварын газар, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд тогтмол хяналт тавьж асгарсан тохиолдолд тухай бүр нь цэвэрлэгээ хийж авч байна. Уурхайн засвар үйлчилгээ хийгдэх явцад асгаралт, бохирдолд хяналт тогтмол хийгддэг.
Газрын доорхи ус		

Хашаатын цав хүрэн нүүрсний уурхай орчмын газрын доорх усны түвшин буурч, нөөц багасах	Уурхайн ус шавхах цоногийн байршлыг оновчтой сонгож ус шавхалтын хэмжээг хамгийн бага байхаар сонгож ажиллах	Хашаатын цав хүрэн нүүрсний уурхай орчмын газрын доорх хөрсний шүүрлийн ус гарч эхэлснээс зумп байгуулж тухайн шүүрлийн усыг тусгай усан санд хуримтлуулан усалгаанд ашиглаж байна.
ШТС, засварын газар зэргээс ШТМ асгарч алдагдсанаар хөрсөнд шингэж, улмаар бага гүний уст үеүдийг бохирдуулах	Шингэн шатах, тослох материал хөрсөн дээр асгарсан үед, тархахаас сэргийлж модны үртэс эсвэл синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах	Уурхайн засвар үйлчилгээний талбайнуудад хөрс хамгаалах давхар дэвсэлт хийгдсэн бөгөөд ШТМ болон тосолгооны материал ямар нэгэн асгаралт үүссэн үед тухайн хөрсийг ухаж ачиж хөрсний бохирдол цуглуулах тусгай талбайд хуримтлуулна.

1. Уурхайн хөрс, чулуулгийн овоолго, ухаш, нүүрсний овоолго зэрэг хүчиллэг урсац үүсэж болзошгүй хэсгүүдийн гадна талаар суваг, шуудуу татах, далан хаалт сэтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч байх,

Уурхайн бүсийн гадна талд хур борооны ус орох, гал түймэр гарах зэрэг эрсдлээс сэргийлсэн хамгаалалтын зурвас болон суваг шуудуу ухаж татсан байна. Энэ нь тухайн бүст гал гарах, үер усны аюулаас сэргийлсэн арга хэмжээнүүд болно.



Зураг 24. Уурхайн гадна талаар татсан суваг шуудуу, хамгаалалтын зурвас

2. Уурхайн ус шавхах цооногийн байршлыг оновчтой сонгож ус шавхалтын хэмжээг хамгийн бага байхаар сонгож ажиллах

Хашаатын цав хүрэн нүүрсний уурхай орчмын газрын доорх усыг гүний усны хяналтын цооног байгуулж хянах ба газрын доорх хөрсний шүүрлийн ус уурхайн 667 түвшинд 2022.09.01-нээс эхлэн гарч эхэлсэн. Уурхай дотор шүүрлийн усны зумп байгуулан тухайн усыг хуримтлуулж тухайн сараас эхлэн уурхайн зам талбайн усалгаанд ашиглаж байна. Одоогийн байдлаар шүүрлийн усыг уурхайн дээд хэсэгт усан сан байгуулан соруулах тухайн усан санд тоолуур тавих ажлууд хийгдэж байна.



Зураг 25. Уурхайн шүүрлийн ус хуримтлуулсан зумп байгуулсан байдал

3. Уурхайн дэвсгэр дэх ШТС, Засварын газар, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон уурхайн хүнд машин техник, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах

Уурхайн шатахуун түгээх станц, засвар үйлчилгээний газар, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд тогтмол хяналт тавьж ажилладаг учраас одоогоор ямар асгаралт, алдагдах тохиолдол бүртгэгдээгүй болно.

4. Шингэн шатах, тослох материал хөрсөн дээр асгарсан үед, тархахаас сэргийлж модны үртэс эсвэл синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах



Зураг 26. Аюултай хаягдал хуримтлуулах тусгай зориулалтын сав байршуулсан байдал



Зураг 27. Уурхайн ШТС болон цэнэглэлт хийх талбай хатуу хучилт хийгдсэн байдал

3. Уурхайн усны хэрэглээндээ хяналт тавьж, сар бүрийн мэдээг гарган орон нутгийн байгаль орчны хяналтын улсын байцаагчид хүргүүлж байх

Унд ахуйн усны хэрэглээ, хяналт

Уурхайн унд-ахуйн буюу технологийн усны хэрэглээг уурхайн лиценцийн талбайд өрөмдсөн 1 худаг, уурхайн кемп дээр гаргасан 2 гүний худгаас хангана. “Вертекс Майнинг Партнерс” ХХК-ний кемпийн ундны усны гүний худгийн ундарга 2.0 л/сек, худгийн өрөмдлөгийн гүн 60 метр, уст давхарга нь 38 метр байна. Технологийн худаг №01 худгийн ундарга 2.0 л/сек, худгийн өрөмдлөгийн гүн 120 метр, уст давхарга нь 97 метр, дундаж зузаан нь 90 метр байна. Технологийн №02 гүний худгийн ундарга 2.0 л/сек, худгийн өрөмдлөгийн гүн 98 метр, уст давхарга нь 38 метр, дундаж зузаан нь 34 метр байна.

Хүснэгт 11. Уурхайн кемпийн ундны усны тоолуурын заалтууд

Тоолуурын дугаар	Тоолуурын заалт баталгаажуулсан огноо	Тоолуурын заалт	Ашигласан усны хэмжээ, м ³
№2107019726	2022.03.31	00332 м ³	332
	2022.04.27	000740 м ³	408
	2022.05.26	001195 м ³	455
	2022.06.27	001638 м ³	436
	2022.07.27	002074 м ³	443
	2022.08.27	002532 м ³	458
	2022.09.27	002093 м ³	371

	2022.10.31	003116 м ³	213
2022 оны 11 сарын байдлаар усны хэрэглээ		3116 м³	3116
			
2022.03.31-ны ундны усны хэрэглээ		2022.04.27-ны ундны усны хэрэглээ	
			
2022.05.26-ны ундны усны хэрэглээ		2022.06.27-ны ундны усны хэрэглээ	
			
2022.07.27-ны ундны усны хэрэглээ		2022.08.27-ны ундны усны хэрэглээ	

Хашаатын цав уурхайн унд- ахуйн зориулалтаар ашигласан усны хэмжээ сар сараар

Зам талбайн тоосжилт дарах усны хэрэглээ, хяналт

Хашаатын цав уурхайн зам талбайн тоосжилтыг засварын талбайд гаргасан гүний худгаас хангадаг. Технологийн гүний худгийн ундарга 1.8 л/сек, худгийн өрөмдлөгийн гүн 120 метр, уст давхарга нь 97 метр байна. Тус технологийн зориулалтаар ашигалах худагт LXSGR-32 маркын 10м³/цаг хэмжих хягзаартай, 32 мм голчтой № 2107019826 дугартай тоолуурыг 1-р лац №024, 2-р лац дугаар ДНАА05356 дугаартай битүүмжилсэн 00001 заалттай) 2022 оны 03 сарын 10-нд тоолуур тавьсан байсан.

Хүснэгт 12. Хашаатын цав уурхайн технологийн худаг №01 усны тоолуурын заалтын баталгаажуулалт

Тоолуурын дугаар	Тоолуурын заалт баталгаажуулсан огноо	Тоолуурын заалт	Ашигласан усны хэмжээ, м ³
№12107019826	2022.03.31	01025 м ³	1025
	2022.04.27	03576 м ³	2551
	2022.05.27	05562 м ³	1986
	2022.06.27	07762 м ³	2060
	2022.07.27	07858 м ³	236
	2022.08.27	07858 м ³	0
	2022.09.27	07858 м ³	0
	2022.10.27	07858 м ³	0
Нийт хэрэглээ		7858 м³	7858

Хүснэгт 13. Хашаатын цав уурхайн технологийн худаг №02 усны тоолуурын заалтын баталгаажуулалт

Тоолуурын дугаар	Тоолуурын заалт баталгаажуулсан огноо	Тоолуурын заалт	Ашигласан усны хэмжээ, м ³
№2107134902	2022.03.31	00300 м ³	300
	2022.04.27	00774 м ³	774
	2022.05.27	04992 м ³	4218
	2022.06.27	08779 м ³	4561
	2022.07.27	11801 м ³	3022
	2022.08.27	15469 м ³	3668
	2022.09.27	18801 м ³	3332
	2022.10.27	21301 м ³	2500
2022 оны 11 сарын байдлаар ус		0021301 м³	21301



2022.03.31-ны уурхайн технологийн худгийн усны тоолуур



2022.04.27-ны уурхайн технологийн худгийн усны тоолуур баталгаажуулалт /VMP технологийн худаг/



2022.04.27-ны уурхайн технологийн худгийн усны тоолуур баталгаажуулалт



2022.05.26-ны уурхайн технологийн худгийн ус ашиглалт



2022.06.27-ны уурхайн технологийн худгийн ус ашиглалт

Усны ашиглалтын тоолууранд тогтмол баталгаажуулалт хийж, төлбөрийг төлөх

2022 оны 3-11 сарын хугацаанд ундны худгаас 3116м³ усыг уурхайн унд ахуй зориулалтаар, Технологийн зориулалтаар худгаас зам талбайн тоосжилтонд ашигласан үйлдвэрлэлийн зориулалтаар м³ 29159 /7858+21301м³/ усыг ашигласан байна. Хашаатын уурхайн 2022 оны 11 сарын байдлаар унд ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрөөс хуулийн дагуу чөлөөлөгдсөн бол 377,622 төгрөг, үйлдвэрийн зориулалтаар ашигласан усны төлбөрт нийт 14,879,839.7 төгрөг төлсөн байна.

Хүснэгт 14. Хашаатын цав уурхайн технологийн зориулалтаар ашигласан усны төлбөр

Сарын ус ашиглалт	Ашигласан усны төлбөр,төг	Нийт усны төлбөр, төгрөг
04 сарын ус ашиглалт	4350 м ³ *510.3	2,219,805.10
05 сарын ус ашиглалт	6205 м ³ *510.3	3,166,411.5
06 сарын ус ашиглалт	6761 м ³ *510.3	3,450,138.3
07 сарын ус ашиглалт	3258 м ³ *510.3	1,667,557.4
08 сарын ус ашиглалт	3668 м ³ *510.3	1,871,780.4
09 сарын ус ашиглалт	3332 м ³ *510.3	1,700,319.6
10 сарын ус ашиглалт	2500 м ³ *510.3	1,275,500
	Нийт ус	14,879,839.7

6.4.Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хүснэгт 15. Хөрсөнд бүрхэвчинд нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Болзошгүй нөлөөлөл	Хөрсөн брхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэрэгжүүлсэн ажил
Хөрсөн бүрхэвч		
<p>Уурхайг ашиглах үед ил уурхайн олборлолтод 564,1га, гадаад овоолгод 294,6 га, нүүрсний агуулах 46.7 га, зам 20 га, ШТС 1га, засварын газарт 10га талбайн үржил шимт хөрсийг хуулан хөрсөн бүрхэвчийг эвдрэлд оруулна.</p>	<p>Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө ашиглалтад өртөх хэсгүүдийн хөрсийг 0.2 метр зузаантай 5 метрээс ихгүй өндөртэй овоолго үүсгэн хэлбэржүүлж үржил шимийг хадгалах</p> <p>Хаягдал чулуулгийн гадаад овоолгыг 17- 18о-аас ихгүй налуутайгаар хэлбэржүүлж шимт хөрсөөр хучин биологийн нөхөн сэргээлт хийх нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>Уурхайн үйл ажиллагаанд өртөх талбайнуудад ашиглалтад өртөхөөс өмнө шимт хөрсийг хэсгүүдийн хөрсийг 0.2 метр зузаантай 5 метрээс ихгүй өндөртэй овоолго үүсгэн</p> <p>Уурхайн хөрсний хуулалт одоогийн байдлаар үргэлжлүүлж хуулалт хийгдэх байна.</p>
<p>Уурхайн үйл ажиллагаатай холбоотой тээврийн хөдөлгөөнөөр олон салаа зам үүсэж улмаар хөрсний эвдрэл, доройтол бий болох</p>	<p>Замын нэгдсэн системтэй болж хурдны хязгаар, чиглэлийг заасан замын тэмдгүүдийг замын салаа, уулзварууд болон холбогдох газарт нийт 35 ширхгийг байршуулах</p>	<p>Замын нэгдсэн системтэй болж хурдны хязгаар, чиглэлийг заасан замын тэмдгүүдийг замын салаа, уулзварууд болон холбогдох</p>
<p>Туслан гүйцэтгэгч байгууллагуудын Засвар үйлчилгээний төвөөс шатах тослох материал хөрсөнд алдагдах хөрсөн бүрхэвч бохирдох</p>	<p>Засвар үйлчилгээний төв болон ШТС-ын талбайг хатуу хучилттай болгох</p>	<p>Уурхайн нутаг дэвсгэр ШТС, Засварын газар, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд тогтмол хяналт тавьж асгарсан тохиолдолд тухай бүр нь цэвэрлэгээ хийж авч байна.</p> <p>ШТС-ын талбайн түлшний агуулах хатуу хучилттай болгож хөрсний бохирдол үүсэхээс хамгаалсан.</p>
<p>Түлшний агуулах, шатахуун түгээгүүрээс болон засварын газраас гарах хаягдал тос асгарч хөрсөн бүрхэвчийг бохирдуулах</p>	<p>ШТМ алдагдахаас сэргийлэх, асгаралд гарч болзошгүй ШТС-ын ШТМ хадгалах сав (резурвар) –нд хамгаалалтын суурь хийх, ялангуяа түлш агуулах босоо савыг давхар гадаргатай барьж байгуулах, босоо савнаас генераторуудад холбосон шугам хоолойн шуудуунд үл нэвчүүлэх хальс хийх, асгарсан үед хэрэглэх шингээгч бодис, материал ((TSSW50W))-ыг зохих газарт байршуулах зэрэг арга хэмжээ авах.</p>	<p>Хашаатын уурхайн ШТС-ын агуулах бүр стандартын шаардлагад нийцсэн хатуу талбайтай байна.</p>
<p>Замын хөдөлгөөнд оролцож байгаа машин техникийн бүрэн бүтэн байдал алдагдах зэргээс тос, тосолгооны материал асгарч хөрсөн бүрхэвчийг бохирдуулах</p>	<p>- Шингэн ШТМ хөрсөн дээр асгарсан тохиолдолд тархахаас сэргийлж модны үртэс эсвэл синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах - ШТМ-аар бохирдсон хөрсийг тээвэрлэн уурхайн бохирдсон хөрс цуглуулах талбайд хүргэж саармагжуулах</p>	<p>Засвар үйлчилгээний талбайд хөрсний бохирдлоос хамгаалсан 2-3 м зузаан хөрсөөр дэвсэлт хийгдсэн.</p>

1. Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө ашиглалтад өртөх хэсгүүдийн хөрсийг 0.3-0.4 метр зузаантай хуулах, шимт 5 метрээс ихгүй өндөртэй овоолго үүсгэн хэлбэржүүлж үржил шимийг хадгалах

Шимт хөрсийг Shantui SD16 маркийн бульдозероор хуулж Liugong clg 835 маркийн утгуурт ачигчаар автосамосвалд ачилт хийж уурхайн хүрээнээс 1.6 км-ийн зайд шимт хөрсний овоолго руу тээвэрлэнэ. Шимт хөрсний овоолгын 4.7-4 метрийн өндөртэй 250 - 300 градусын налуутайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулсан. Шимт хөрсийг уурхай, овоолгын суурийн талбайгаас 0.2 метрийн зузаантай хуулагдсан. Нийт 2022 оны 11 сарын байдлаар 14.0 га талбайд шимт хөрсний овоолго байгуулан хадгалж байгаа ба 972,042 м³ шимт хөрс хуулагдсан байна.



Зураг 28. Уурхайн шимт хөрсний овоолго

2. Хаягдал чулуулгийн гадаад овоолгыг 17-18о-аас ихгүй налуутайгаар хэлбэржүүлж шимт хөрсөөр хучин биологийн нөхөн сэргээлт хийх нөхцөлийг бүрдүүлэх

Уурхайгаас хуулж буй хөрсийг гадаад хөрсний овоолго үүсгэж уурхайгаас 1,0 км зайтай гадаад овоолгоп 35- 37-аас ихгүй налуутайгаар хэлбэржүүлж хадгалж байна.



Зураг 29. Уурхайн хуулсан хөрсний овоолго үүсгэж хадгалсан байдал

3. Засвар үйлчилгээний төв болон ШТС-ын талбайг хатуу хучилттай болгох

Засварын төвийн хог хаягдал түр хадгалах байгууламжыг хийхдээ 30 см зузаантай материалаар дэвсэлт хийж, дээр нь гялгар пилонк дэвсээд дахин 10 см материалаар үечлэн дэвсэлт хийж байгуулсан. Энэ нь хог хаягдал хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулахаас сэргийлэх зорилготой юм. Мөн засвар үйлчилгээ хийх талбайн шимт хөрсийг бүрэн хуулж уурхайн олборлолтын үед гарсан нунтаг материалаар дэвсэлт хийж ашиглаж байна. Мөн засвар үйлчилгээний талбайн орчимд шимт хөрс бүхий талбайд машин техник парклах болон зөвшөөрөлгүй шинээр зам үүсгэж явахаас сэргийлж ажиллаж байна.



Зураг 30. Уурхайн засвар үйлчилгээний талбайнуудад хөрс хийж хамгаалсан байдал



Зураг 31. Уурхайн ШТС, засвар үйлчилгээний талбай, хог хаягдлын цэг, аюултай хаягдлын талбайг хатуу хучилт хийж хөрсний бохирдлоос хамгаалсан байдал

4. Шингэн ШТМ хөрсөн дээр асгарсан тохиолдолд тархахаас сэргийлж модны үртэс эсвэл синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах-ШТМ-аар бохирдсон хөрсийг тэвэрлэн уурхайн бохирдсон хөрс цуглуулах талбайд хүргэж саармагжуулах

Уурхайн нутаг дэвсгэр ШТС, Засварын газар, явуулын цистерн зэрэг ШТМ алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд тогтмол хяналт тавьж асгарсан тохиолдолд тухай бүр нь цэвэрлэгээ хийж, бохирдсон хөрсийг тусгайлан хуримтлуулах цэгт хадгалж бай



Зураг 32. Засварын талбайд хайрган дэвсэлт хийсэн байдал



Зураг 33. Засварын талбайд хайрган дэвсэлт хийсэн байдал



Зураг 34. Уурхайн бохирдсон хөрс хадгалах талбай



Зураг 35. Уурхайн аюултай хаягдал хуримтлуулах сав далд байршуулсан байдал



Зураг 36. Уурхайн аюултай хаягдал хуримтлуулах сав

5. Замын нэгдсэн системтэй болж хурдны хязгаар, чиглэлийг заасан замын тэмдгүүдийг замын салаа, уулзварууд болон холбогдох газарт нийт шаардлагатай тэмдэг байршуулах

Уурхайн дотоод замын хөдөлгөөнд оролцох хурдны тогтсон хязгаар 30/40км/цаг байдаг. Тухайн уурхайн замын хөдөлгөөний хурдын журмын дагуу хязгаарлаж, түүнд тогтмол хяналт тавьж ажилладаг.



Зураг 37. Уурхайн дотоод замын хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглэгээ

5.5. Ургамлан нөмрөг, амьтаны нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Уурхайн орчмын ургамлын нөмрөг нь олборлолт, баяжуулалтын уурхайн үйл ажиллагаанд өртсөн учраас бүхэлдээ талхагдалд орж нөлөөлөлд орсон тухай газрын төлөв байдал хянан баталгаагаар тодорхойлсон. Уурхайн үйл ажиллагаанаас ургамлын бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд газар хөндөлтийн хяналт, олон салаа зам гаргахгүй байх тогтсон нэг маршрутаар техник хэрэгслүүдээ явуулах, уурхайн дотоод замыг тэмдэгжүүлэн ялгах, уурхайн кемпийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлуудыг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 16. Ургамлан нөмрөг, амьтны аймагт нөлөөлөх байдлыг бууруулах арга хэмжээний зөвлөмж

Болзошгүй нөлөөлөл	Амьтан, ургамлын үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хэрэгжүүлсэн ажил
Хашаатын цавын хүрэн нүүрсний уурхайг ашиглах явцад уурхайн олборлолт болон хөрсний гадаад овоолго, нүүрсний овоолго, гадаад, дотоод тээврийн замын талбайн хэмжээгээр ургамлан нөмрөг шимт хөрстэй хамт хуулагдан устана	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө ашиглалтад өртөх хэсгүүдийн хөрсийг 0.2 метр зузаантай 5 метрээс ихгүй өндөртэй овоолго үүсгэн хэлбэржүүлж үржил шимийг хадгалах	Уурхайн үйл ажиллагаанд өртөх талбайнуудын шимт хөрсийг 0.2 метр зузаантай хуулж, уурхайгаас 1.6 км-т 5 метрээс ихгүй өндөртэй шимт хөрсний овоолго үүсгэн хадгалж байна.
	Хаягдал чулуулгийн гадаад овоолгыг 17-18о- аас ихгүй налууутайгаар хэлбэржүүлж шимт хөрсөөр хучин биологийн нөхөн сэргээлт хийх нөхцөлийг бүрдүүлэх	Уурхайн хуулж буй хөрсний овоолгыг тусгайлан хадгалж байна.
Шимт хөрсний овоолгын талбайд ургамлан нөмрөг дарагдах, шимт хөрсний ялзмагийн хэмжээ буурах	2 жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд болон хажуу талыг хэлбэршүүлж олон наст ургамал тарих.	Шимт хөрсийг тусгай талбайд хөрсний овоолго үүсгэн хадгалж байна.

<p>Хашаатын цавын хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах явцад нүүрсний овоолго болон нүүрс ачиж буулгах явцад тоосжилт үүснэ. Дээрх үүссэн тоосжилтоос уурхайн хэсгийн болон түүний ойр орчмын ургамлан нөмрөгийн морфологид өөрчлөлт орох, фотосинтезийн эрчим буурах</p>	<p>Ургамлан нөмрөгийн мониторингийн ажлыг жил бүр тогтмол явуулж, нөлөөллийг тогтоож бууруулах</p>	<p>Хашаатын цав уурхайн Ургамлын мониторингийн 12 цэгт хяналт мониорингийн ажлыг 7сард хийж гүйцэтгэсэн болно. Тухайн монирторингийн цэгүүдэд жил бүр тогтмол хяналт мониторинг хийж явахаар төлөвлөж байна.</p>
<p>Уурхайн суурины 10 га талбайн ургамлан нөмрөг барилга байгууламж барих явцад устана. Цаашид байнгын хөл хөдөлгөөнөөс байгууламжуудын ойр орчмын ургамлан нөмрөгийн доройтох талбайн хэмжээ нэмэгдэх.</p>	<p>Уурхайн ажилчдын хотхоны орчны эвдэрсэн газрыг нөхөн сэргээж 2 га-аас багагүй талбайг зүлэгжүүлж, ногоон байгууламж байгуулан байнгын арчилгаа, тордолт хийх;</p>	<p>Уурхайн ажилчдын хотхоны орчинд 1.6 га талбай бүхий газарт Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл байгуулж мод тарьсан.</p>
<p>Уурхайн бүхий л үйл ажиллагааны явцад болон зам даган шилжин ирэх суурьшил зэргээс бүс нутгийн бэлчээрийн ургамлын төрөл, зүйлийн тоо багасах, доройтох</p>	<p>Бэлчээрийн доройтлын бүсүүдийг тогтоох, эдгээр бүсүүдэд бэлчээрийн ургамлын доройтлын шалтгааныг тодорхойлж уурхайн шууд болон шууд бус нөлөөгөөр доройтсон нь тогтоогдвол тэдгээрийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>Одоогоор уурхайн бүст бэлчээрийн доройтол үүсэх байдал ажиглагдаагүй малын бэлчээр хэвийн байдалтай байна.</p>
<p>Амьтаны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах</p>		
<p>Хашаатын цав нүүрсний ил уурхайгаас нүүрс олборлох явцад, хөрс, нүүрсийг ачиж тээвэрлэх, буулгах үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, түүний яндан, дизель станцын яндан болон уурын зуухны яндангаас гарах утаанаас амьтад дайжих</p>	<p>Уурхайгаас салхин дагууд 1 ба 5 км зайд агаарын чанарын стандарт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байх</p>	<p>Уурхайн тоосжилтыг тогтмол сар бүр гүйцэтгэж хяналт тавьж ажилладаг болно.Тухайн хэмжилтүүдийн үр дүнгээр зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй болно.</p>
	<p>Уурхайн талбай, түүний эргэн тойронд зэрлэг ан амьтдын мониторинг хийж амьтдын байршилд уурхай хэрхэн нөлөөлж буй холбогдлыг судлах (Уурхайгаас 3 км-ийн радиуст мэрэгчдийн мониторингийн цэгэн 10 км-ын радиуст туруутны маршрутын 1 талбай)</p>	<p>Уурхайн талбай, түүний эргэн тойронд зэрлэг ан амьтдын мониторинг хийх 4-н хяналтын цэг тогтоосон ба түүний дагуу хяналт, амьтаны мониторинг хийж байна.</p>
	<p>Зэрлэг ан амьтан хамгаалах биотехникийн арга хэмжээ авна (цаг агаар хүндэрсэн үед зэрлэг амьтдад өгөх 13 тн өвс, тэжээл бэлтгэж нөөцөлсөн байх)</p>	<p>Одоогоор тухайн бүс нутаг зэрлэг амьтаны өвс, тэжээл бэлтгэх хэмжээнд хүртэл нөхцөл байдал ажиглаагдаагүй байна. Уурхайн орчимд цагаан зээрийн бэлчээрлэх нөхцөл хэвийн байна.</p>

1. Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө ашиглалтад өртөх хэсгүүдийн хөрсийг 0.4 метр зузаантай 5 метрээс ихгүй өндөртэй овоолго үүсгэн хэлбэржүүлж үржил шимийг хадгалах

Уурхайн үйл ажиллагаанд өртөх талбайнуудын шимт хөрсийг 0.3-0.5 метр зузаантай хуулж, уурхайгаас 1.6 км-г 5 метрээс ихгүй өндөртэй шимт хөрсний овоолго үүсгэн хадгалж байна. Тус уурхайн шимт хөрс хуулах журмын дагуу хөрс хуулалт, хадгалалтын хянан бүртгэлжүүлдэг.





График 3. Хашаатын цав уурхайн хуулсан шимт хөрсний хэмжээ



Зураг 38. Хашаатын цавын хүрэн нүүрсний уурхайн хуулж хадгалсан шимт хөрс

2. Хаягдал чулуулгийн гадаад овоолгыг 17-180- аас ихгүй налуутайгаар хэлбэржүүлж шимт хөрсөөр хучин биологийн нөхөн сэргээлт хийх нөхцөлийг бүрдүүлэх

Уурхайгаас хуулж буй хөрсийг гадаад хөрсний овоолго үүсгэж уурхайгаас 1,0 км зайтай гадаад овоолго үүсгэн 35-37-аас ихгүй налуутайгаар 10 сарын байдлаар хөрсний овоолгоо талбай 149.0 га болсон байна.



3. 2 жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд болон хажуу талыг хэлбэршүүлж олон наст ургамал тарих

Уурхайн үйл ажиллагаанд өртөх талбайнуудын шимт хөрсийг 0.3-0.5 метр зузаантай хуулж, уурхайгаас 1.6 км-г 5 метрээс ихгүй өндөртэй шимт хөрсний овоолго үүсгэн хадгалж байна. 2022 онд 1.7 га талбай бүхий шимт хөрсийг хамгалах зорилгоор ургамалжуулсан.



Зураг 39. Хуулж хадгалсан шимт хөрс ургамалжуулаагүй байдал




Зураг 40. Хуулж хадгалсан шимт хөрс ургамалжуулсан, хөрсний гадарга ургамалжсан байдал

4. Ургамлан нөмрөгийн мониторингийн ажлыг жил бүр тогтмол явуулж, нөлөөллийг тогтоож бууруулах

Хашаатын цав уурхайн Ургамлын мониторингийн 12 цэгт хяналт мониорингийн ажлыг 7 сард хийж гүйцэтгэсэн болно. Тухайн монирторингийн цэгүүдэд жил бүр тогтмол хяналт мониторинг хийж явахаар төлөвлөж байна.







Зураг 41. Хашаатын цав уурхайн ургамлын мониторинг цэгүүд

5. Уурхайн ажилчдын хотхоны орчны эвдэрсэн газрыг нөхөн сэргээж 2 га-аас багагүй талбайг зүлэгжүүлж, ногоон байгууламж байгуулан байнгын арчилгаа, тордолт хийх;

Уурхайн ажилчдын хотхоны орчинд 1.6 га талбай бүхий газарт Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд уурхайн кемпийн урьд хэсэг Ногоон төгөл байгуулж мод тарьсан.



6. Бэлчээрийн доройтлын бүсүүдийг тогтоох, эдгээр бүсүүдэд бэлчээрийн ургамлын доройтлын шалтгааныг тодорхойлж уурхайн шууд болон шууд бус нөлөөгөөр доройтсон нь тогтоогдвол тэдгээрийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх


Одоогоор уурхайн бүст бэлчээрийн доройтол үүсэх байдал ажиглагдаагүй малын бэлчээр хэвийн байна.

7. Уурхайгаас салхин дагууд 1 ба 5 км зайд агаарын чанарын стандарт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байх

Уурхайн тоосжилтыг тогтмол сар бүр гүйцэтгэж хяналт тавьж ажилладаг болно. Тухайн хэмжилтүүдийн үр дүнгээр зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй болно.

8. Уурхайн талбай, түүний эргэн тойронд зэрлэг ан амьтдын мониторинг хийж амьтдын байришилд уурхай хэрхэн нөлөөлж буй холбогдлыг судлах Уурхайгаас 3-5 км-ийн радиуст мэрэгчдийн мониторингийн цэгэн 10 км-ын радиуст туруутны маршрутын 1 талбай)

Уурхайн талбай, түүний эргэн тойронд зэрлэг ан амьтдын мониторинг хийх 4-н хяналтын цэг тогтоосон ба түүний дагуу хяналт, амьтаны мониторинг хийж байна.



Зураг 42. Хашаатын цав уурхайн талбай орчмын амьтны мониторинг судалгааны цэгүүд

9. Зэрлэг ан амьтан хамгаалах биотехникийн арга хэмжээ авна (цаг агаар хүндэрсэн үед зэрлэг амьтдад өгөх 13 тн өвс, тэжээл бэлтгэж нөөцөлсөн байх

Одоогоор тухайн бүс нутаг зэрлэг амьтаны өвс, тэжээл бэлтгэх хэмжээнд хүртэл бэлчээрийн доройтол үүсэх нөхцөл байдал ажиглаагдаагүй байна. Уурхайн орчимд цагаан зээрийн бэлчээрлэх нөхцөл хэвийн гэж үзэж байна.

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Хашаатын цав”-ын хүрэн нүүрсний уурхай нь 2022 онд 0.8 га талбайд нөхөн сэргээх ажил, ажилчдын хотхон амрах байрны ойролцоо 0.5 га талбайд мод тарих талбайг хашаалах ажлыг хийж гүйцэтгэх төлөвлөгөөний дагуу тухайн ажлуудыг хэрэгжилтийг ханган ажилласан болно. Тус ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж олон наст ургамал тарьж, зүлэгжүүлэх, мод тарих ажлыг гүйцэтгэсэн.

Хүснэгт 17. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөөний биелэлт

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Хамрах хүрээ
Шимт хөрсийг хамгаалах	Шимт хөрсний овоолгоос ялзмагийн алдралыг багасгахын тулд ургамалжуулалтын ажлыг гүйцэтгэх.	Уурхайн тусгайлан хадгалж буй шимт хөрсийг ургамалжуулах ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж 1.7 га шимт хөрсний захын хэсгээс ургамалжуулах ажлын гүйцэтгэсэн болно.
Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл байгуулах	Төслийн талбайн 1.3 га талбайд онцлогт тохирсон ургамал, мод тариалан ногоон төгөл байгуулах. /1 хүн 30 мод тарих хөтөлбөр компанид хэрэгжүүлнэ.	Баянтүмэн сумын нутагт тухайн хөтөлбөрийн хүрээнд мод тарих газраас сонгон тодорхойлсон. Энэ жил хашаажуулах ажлууд хийгдэж намрын мод тарих улиралд мод тарихаар төлөвлөн ажиллаж байна. Мод

1. Шимт хөрсний овоолгоос ялзмагийн алдралыг багасгахын тулд ургамалжуулалтын ажлыг гүйцэтгэх.

Уурхайн олборлолт, үйл ажиллагаанд өртөх газрын шимт хөрсийг 30.0-40.0 см зузаантай тусгай талбайд шимт хөрс хуулах стандартын дагуу хуулж хадгалж байна. 2022 онд нийт 970052 м³ шимт хөрсийг хуулж, тусгай талбайд хадгалж хамгаалах арга хэмжээ авсан. 2022 онд 1.7 га талбай бүхий шимт хөрсийг ургамалжуулах ажлыг төлөвлөн гүйцэтгэсэн болно.

Ургамалжуулсан талбай:

Шимт хөрсний овоолгын талбайг жил бүр тодорхой хэмжээгээр ургамалжуулах ажил гүйцэтгэхээр төлөвлөж байна. Энэ жил 1.7 га талбай бүхий шимт хөрсийг ургамалжуулсан.



Зураг 43. Уурхайн ургамалжуулах шимт хөрсний овоолго

Хүснэгт 18. Тарих ургамлын хэмжээ

№	Ургамлын нэр	Латин нэр	1.0 га-д, кг
1	Царгас	Medicago L	8-10
2	Хүцэнгэ	Onobrychis L	25-30
3	Хошоон	Melilotus Hill	15-20
4	Согоовор	Bromus L	18
5	Өлөнгө	Elymus L	15-20
6	Ерхөг	Agropyron L	15-18





Зураг 44. Уурхайн ургамалжуулах талбайн шимт хөрсийг бэлдэж буй байдал



Зураг 45. Уурхайн шимт хөрсийг ургамалжуулах ажлын явц



Зураг 46. Ургамалжуулсан талбайн олон настын ургамал ургасан 6 сарын сүүлээр байдал



Зураг 47. Уурхайн ургамалжуулсан шимт хөрсний олон наст ургамлын ургасан байдал

2. Төслийн талбайн 1.3 га талбайд онцлогт тохирсон ургамал, мод тариалан ногоон төгөл байгуулах. /1 хүн 30 мод/ тарих хөтөлбөр компанид хэрэгжүүлнэ
 Хашаатын цав уурхайн кемпийн урьд хэсэгт 1.6 га талбай бүхий газарт намрын мод тариалалтыг 2022.10.27-ны өдөр зохион байгуулан ажилласан. Кемпийн ногоон байгууламж, ногоон төгөл зориулалтаар 1650 ш мод тарьсан болно. Тус тарьсан модны 1200 улиас 400 хайлаас нэг настай суулгац тарьж суулгасан болно.



Зураг 48. Уурхайн кемпийн бүст ногоон төгөл байгуулан намрын мод тариалалт хийх ажлын явц





3. MV-020936 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн еологи, геотехникийн судалгааны өрөмдлөгийн ажлын нөхөн сэргээлт

Геологи, геотехникийн судалгааны ажлыг 2022 оны 05 дугаар сарын 26 өдөр эхлэн 2022 оны 06 дугаар сарын 09 ны өдөр гүйцэтгэж дуусны дараа тухайн цоонгуудад нөхөн сэргээлтийн ажлуудыг гүйцэтгэсэн. КНДН2201 цооногийг 2022 оны 05 сарын 30 өдөр нээж 2022оны 05 сарын 30 өдөр хаав. Цооногийн гүн 219 т/м өрөмдөж, өрөмдсөн газрын нөхөн сэргээлтийг өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэсэн “Элгэн” ХХК-н инженер техникийн ажилчид болон Хашаатын цав уурхай хариуцсан мэргэжилтэнүүд нар газар дээр нь акт үйлдэн гүйцэтгэж фото зургаар баримтжуулан болно.



КНДН2201 цооногийг 2022 оны 05 сарын 30 өдөр нээж 2022 оны 05 сарын 30 өдөр хаав. Цооногийн гүн 219 т/м өрөмдөж, өрөмдсөн газрын нөхөн сэргээлтийг өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэсэн



КНДН2202 цооногийг геотехникийн хэмжилт хийх, бичиглэл хийх, дээжлэх зорилгоор 2022 оны 05 сарын 27 өдөр нээж 2022 оны 05 сарын 30 өдөр хаалаа. Цооногийг 192 т/м гүн өрөмдөж, өрөмдсөн газрын нөхөн сэргээлтийг газар дээр нь акт үйлдэн гүйцэтгэж фото зургаар баримтжуулан хийв.



КНДН2203 цооногийг геотехникийн хэмжилт хийх, бичиглэл хийх, дээжлэх зорилгоор 2022 оны 05 сарын 31 өдөр нээж 2022 оны 06 сарын 02 өдөр хаалаа. Цооногийг 204 т/м гүн өрөмдөж, өрөмдсөн газрын нөхөн сэргээлтийг газар дээр нь акт үйлдэн гүйцэтгэж фото зургаар баримтжуулан хийв.



КНДН2204 цооногийг геотехникийн хэмжилт хийх, бичиглэл хийх, дээжлэх зорилгоор 2022 оны 05 сарын 31 өдөр нээж 2022 оны 06 сарын 02 өдөр хаалаа. Цооногийг 150 т/м гүн өрөмдөж, өрөмдсөн газрын нөхөн сэргээлтийг газар дээр нь акт үйлдэн гүйцэтгэж фото зургаар баримтжуулан хийв.





KNDH2205 цооногийг геотехникийн хэмжилт хийх, бичиглэл хийх, дээжлэх зорилгоор 2022 оны 06 сарын 04 өдөр нээж 2022 оны 06 сарын 08 өдөр хаалаа. Цооногийг 204 т/м гүн өрөмдөж, өрөмдсөн газрын нөхөн сэргээлтийг газар дээр нь акт үйлдэн гүйцэтгэж фото зургаар баримтжуулан хийв.



KNDH2206 цооногийг геотехникийн хэмжилт хийх, бичиглэл хийх, дээжлэх зорилгоор 2022 оны 06 сарын 03 өдөр нээж 2022 оны 06 сарын 05 өдөр хаалаа. Цооногийг 120 т/м гүн өрөмдөж, өрөмдсөн газрын нөхөн сэргээлтийг газар дээр нь акт үйлдэн гүйцэтгэж фото зургаар баримтжуулан хийв.



KNDH2207 цооногийг геотехникийн хэмжилт хийх, бичиглэл хийх, дээжлэх зорилгоор 2022 оны 05 сарын 23 өдөр нээж 2022 оны 05 сарын 27 өдөр хаалаа. Цооногийг 165 т/м гүн өрөмдөж, өрөмдсөн газрын нөхөн сэргээлтийг газар дээр нь акт үйлдэн гүйцэтгэж фото зургаар баримтжуулан хийв.





КНДН2208 цооногийг геотехникийн хэмжилт хийх, бичиглэл хийх, дээжлэх зорилгоор 2022 оны 05 сарын 23 өдөр нээж 2022 оны 05 сарын 26 өдөр хаалаа. Цооногийг 144 т/м гүн өрөмдөж, өрөмдсөн газрын нөхөн сэргээлтийг газар дээр нь акт үйлдэн гүйцэтгэж фото зургаар баримтжуулан хийв.



КНДН2209 цооногийг геотехникийн хэмжилт хийх, бичиглэл хийх, дээжлэх зорилгоор 2022 оны 06 сарын 04 өдөр нээж 2022 оны 06 сарын 07 өдөр хаалаа. Цооногийг 231 т/м гүн өрөмдөж, өрөмдсөн газрын нөхөн сэргээлтийг газар дээр нь акт үйлдэн гүйцэтгэж фото зургаар баримтжуулан хийв.



КНДН2210 цооногийг геотехникийн хэмжилт хийх, бичиглэл хийх, дээжлэх зорилгоор 2022 оны 06 сарын 05 өдөр нээж 2022 оны 06 сарын 09 өдөр хаалаа. Цооногийг 216 т/м гүн өрөмдөж, өрөмдсөн газрын нөхөн сэргээлтийг газар дээр нь акт үйлдэн гүйцэтгэж фото зургаар баримтжуулан хийв.

7. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11, 8.4.6, 9.6., засгийн газрын 2013 оны 374 тогтоолын 2 дугаар хавсралтын Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.2, 5.3., БОНХ-ийн сайдын 117-р тоот тушаалын 2 дугаар хавсралт, Байгаль орчин нөлөөллийн үнэлгээний аргачлалын 2.1., Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 5.4-т ту тус заасны дагуу “Меланж” ХХК-ний Хашаатын цав уурхай нь Биологийн олон янз байдлыг Дүйцүүлэн хамгаалах ажлыг хэрэгжүүлэн ажилласан.

Хүснэгт 19. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлтийн биелэлт

Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Биелэлт
Төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээ	Хашаатын цав хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаа явагдах талбайгаас хамгийн ойр орших, дүйцүүлэх хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тохиромжтой газар нь Тосон хулстай, Яхь нуурын байгалийн нөөц газар юм. “Меланж” ХХК-ийн зүгээс Хашаатын цав хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн хүрээнд дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг Тосон хулстай, Яхь нуурын байгалийн нөөц газруудын 2022 оны менежментийн төлөвлөгөөнд багтсан арга хэмжээг дэмжиж, хамгаалалтын захиргаатай хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй.	Тарвага нутагшуулах БОАЖЯамны зөвшөөрөлтэй “Авралын Эрэлд” ХХК-тай хамтран 2022.08.04-нд 25 тоо толгой тарвагыг Хашаатын цав уурхайгаас 65 км орчим зайтай Баянтүмэн сумын 2р багийн нутаг Хутагт уул нэртэй орон нутгийн хамгаалалттай газарт Монгол тарвагыг сэргээн нутагшуулах ажлыг амжилттай гүйцэтгэсэн
	Хашаатын цав хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаа явагдах талбайгаас хамгийн ойр орших, дүйцүүлэх хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэхэд сум орон нутгийн Байгаль орчны газар болон байгаль орчны мэргэжилтэнтэй нягт хамтран ажиллах орон нутгийн Байгаль орчны газраас санал болгосон байгаль орчны хамгаалах нөхөн сэргээх ажил дээр хамтран ажиллах нь зүйтэй	Дорнод аймгийн БОАЖГ газрын саналыг авч, тухайн газраас санал болгож тогтоож өгсөн бүс нутагт эвдэрсэн газарт 1.7 га эвдэрч орхигдсон талбайн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн болно.

1. Хашаатын цав хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаа явагдах талбайгаас хамгийн ойр орших, дүйцүүлэх хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, Тосон хулстай, Яхь нуурын байгалийн нөөц газруудын 2022 оны менежментийн төлөвлөгөөнд багтсан арга хэмжээг дэмжиж, хамгаалалтын захиргаатай хамтран хэрэгжүүлэх

Хашаатын цав уурхайн Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд аймгийн БОАЖГ, Баянтүмэн сумын засаг даргын тамгын газар, Дорнод аймгийн ТХГН-ийн захиргааны саналыг үндэслэн Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тухайн байгууллагуудын саанлыг үндэслэн тухайн ажлыг зохион байгуулсан.

Иймээс манай Хашаатын цав хүрэн нүүрсний ил уурхайн 2022 оны Дүйцүүлэн хамгаалах Биологийн олон янз байдлыг нөхөн хамгаалах ажлаар Монгол орны хээрийн экосистем бүрэлдэн тогтох, тогтвортой хадгалагдахад зайлшгүй чухал нөлөөтэй амьтдын нэг Монгол тарваганы тархац, байршил, нягтшилаас олон жил дараалан хайр

гамгүй, тооцоо судалгаа муутай агнасан болон байгаль цаг уурын тааламжгүй хүчин зүйлээс үүдэн, ихэнх нутагт тарваганы хэвийн үржил, нөхөн төлжилт, бүлийн зөв бүтэц алдагдаж, тархац нутаг тасархайтан хумигдаж, тоо толгой, нөөц эрс багасан зарим нутагт устаж үгүй болж байна.

Сүүлийн жилүүдэд нутгийн ард иргэд, байгаль хамгаалагчид, судлаач, эрдэмтэд, олон улсын төсөл, хөтөлбөрийн санаачлаагаар Монгол тарвага сэргээн нутагшуулах ажлууд хийгдэж байгааг манай компани дэмжин Дорнод аймгийн Баянтүмэн сумын 2-р багийн нутагт Хутаг уул нэртэй газарт өмнө тухайн нутагт тарвага байсан сүүлийн үед эрс багасан устгаж үгүй болсон газарт Монгол тарвага сэргээн нутагшуулах ажлыг санаачлаан гүйцэтгэсэн болно.

“Меланж” ХХК-наас БОАЖГ, Баянтүмэн сумын ЗДТГ, тусгай хамгаалалтай газруудын саналыг үндэслэн Дүйцүүлэн хамгаалах ажлаар 25-н тоо толгой Тарвага нутагшуулах ажлыг хаана гүйцэтгэх боломжтой газар нутгийг тухайн газруудын саналыг үндэслэн сонгосон болно. Үүнд:

- Дорнод аймгийн тусгай хамгаалалтын захиргаа нь санал болгосон газар Баянтүмэн нутагт биш, Дорнод аймгийн хойд хэсгийн сумууд
- Баянтүмэн сумын ЗДТГазраас авсан санлын дагуу Баянтүмэн сумын нутагт орших Тосон хулстай Байгалийн нөөц тусгай хамгаалалттай газар нутаг болох Хотон нуур орчим тухайн ажлыг гүйцэтгэх
- Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын санал болгосноор Баянтүмэн сумын 2-р багийн нутаг дэвсгэрт Хутагт уул орон нутгийн хамгаалалттай газар, мөн Хашаатын цав уурхайн орчмын тарвагатай газар



МЕЛАНЖ ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Чингэсийн оргон чөлөө-8,
Алтай буюудинг, 3-р давхар, 302 тоот
Утас: (976)-88886900, 99066904.

2022.05.13 № 01/215

төвий _____ -ны № _____ -т

Г ЯХЬ НУУРЫН БАЙГАЛИЙН
НӨӨЦ ГАЗРЫН ЗАХИРГААНД Г

Г Хүсэлт гаргах тухай Г

Дорнод аймгийн Баянтүмэн нутагт орших “Хашаатын” цав хүрэн нүүрсний уурхайн багтагдсан 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний дагуу төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй билээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр тухайн бүс нутгийн орон нутгийн хамгаалалттай газрууд, Яхь нуурын байгалийн нөөц газруудын 2022 оны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээг дэмжиж, хамгаалалтын захиргаатай хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй” гэж заасан болно.

Иймээс танай Байгалийн нөөцийн газарт төлөвлөгдөж буй биологийн олон янз нэмэгдүүлэх, хамгаалах чиглэлийн ажлууд дээр хамтран ажиллах саналтай байна.

Иймээс манай хүсэлтийн дагуу тухайн ажлуудыг тодорхойлж өгнө үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЦЭНДСҮРЭН



“МЕЛАНЖ” ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-8,
Алтай буюудинг, 3-р давхар, 302 тоот
Утас: +976 9011 1660, 9906 6904
И-мэйл: sec@khashaatcoal.com

2022.05.10 №: 01/205
танай _____ -ын №: _____ -т

ДОРНОД АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ АЯЛАЛ
ЖУУЧЛАЛЫН ГАЗАРТ

Хүсэлт гаргах тухай

“Хашаатын цав” хүрэн нүүрсний уурхайн 2022 оны батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний дагуу төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй билээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд “Төслийн үйл ажиллагаа явагдах талбайгаас хамгийн ойр орших, дүйцүүлэх хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэхэд сум орон нутгийн Байгаль орчны газар хамтран ажиллах орон нутгийн Байгаль орчны газраас санал болгосон байгаль орчны хамгаалах нөхөн сэргээх ажил дээр хамтран ажиллах нь зүйтэй” гэж тусгагдсаны дагуу танай байгууллагаас дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд танайхаас санал болгож буй эвдэрсэн газруудыг нөхөн сэргээх, уурхайн орчмын хамгаалах шаардлагатай байгаа булаг, шандыг хамгаалах, Хэрлэн голын дагуу бургасан ойг нөхөн хамгаалах, хашаажуулах гэх мэт ажлуудыг урьдчилсан байдлаар санал болгосон байна.

Иймд манайхаас дүйцүүлэн хамгаалах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллах тул тухайн чиглэлээр хийгдэх ажлыг тодорхой болгож өгнө үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЦЭНДСҮРЭН

00000070

<p style="text-align: center;">  ДОРНОД АЙМАГ ДАРХАН ЦААЗАТ ГАЗРУУДЫН ДОРНОД ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА 21075 Чойбалсан, Дорнод аймгийн Засаг дарга Утас: 7058-1173, E-mail: dornodnong@97@gmail.com Website: www.dornodnong.gov.mn <u>2022.06.06</u> № <u>30</u> таний <u>2022.05.13</u> -ны № <u>01/215</u> </p> <p style="text-align: center;"> МЕЛАНЖ ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ЦЭНДСҮРЭН ТАНАА </p> <p>Танай компани 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусгаж дүйцүүлэн хамгаалах чиглэлээр Яхь нуурын БНГ-т биологийн олон янз байдлыг хамгаалахад хамтран ажиллах хүсэлт гаргасныг дэмжиж байна. Тус БНГ-ын Зүүн мөглий гэдэг газар буюу И48°51'21.5"; E114°05'07.1" байршилд 50 толгой монгол тарвага нутагшуулах ажилд хамтран ажиллах саналтай байна.</p> <p style="text-align: center;">  ДАРГА <u>Д. ДАШДОРЖ</u> </p> <p style="text-align: right; color: blue;">270622044</p>	<p style="text-align: center;">  ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРГЭЖҮҮГЭГЧ АГЕНТБАГ БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР 21075 Чойбалсан, Дорнод аймгийн Утас/Факс: 7058-3529 </p> <p style="text-align: center;"> <u>2022.06.27</u> № <u>353</u> таний _____ -ны № _____ </p> <p style="text-align: center;"> МЕЛАНЖ ХХК-Н ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ЦЭНДСҮРЭН ТАНАА </p> <p>"Хашаатын цав" хүрэн нүүрсний уурхайн 2022 оны батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийж гүйцэтгэх тарвага нутагшуулах ажлыг дэмжиж байгаа бөгөөд Баянтүмэн сумын 2 дугаар багийн нутаг "Хутаг уул" нэртэй газарт нутагшуулах саналтай байна.</p> <p style="text-align: center;"> ДАРГА  А. АГАНТУЛГА </p> <p style="text-align: right; color: blue;">280622091</p>
---	---


 ДОРНОД АЙМАГ
 БАЯНТҮМЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА
 21050 Цэцэн дүр, Баянтүмэн сум,
 Утас: 7058-6302
2022.06.17 № 2/304
 таний _____ -ны № _____

МЕЛАНЖ ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ
 ЗАХИРАЛ Д.ЦЭНДСҮРЭН
 ТАНАА

Танай компани 2022 оны менежментийн төлөвлөгөөндөө дүйцүүлэн хамгаалах чиглэлээр Тосон хулстай Байгалийн нөөц газарт биологийн олон янз байдлыг хамгаалахад хамтран ажиллах хүсэлт гаргасныг дэмжиж байна.

Тус Байгалийн нөөц газар нь И 48.06916, E 114.51656 байршилд 50 толгой монгол тарвага нутагшуулах ажилд хамтран ажиллах саналтай байна.

ОРЛОГЧ ДАРГА  З. БАТБАЯР

030622324

Зураг 49. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд холбогдох байгууллагуудаас санал авсан холбогдох бичгүүд



Зураг 50. Тосон хулстай байгалийн нөөц газрын Хотон нуур орчим тарвага нутагшуулах боломжтой газрыг аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүд, Баянтүмэн сумын БОУХБ нарын хамт үзсэн



Зураг 51. Хашаатын цав уурхай орчим тарвага нутагшуулах боломжтой газар байгаа эсэхийг аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүд, Баянтүмэн сумын БОУХБ нарын хамт үзсэн



Зураг 52. Уурхайгаас 70 орчим км-н зайтай Хутагт уул орон нутгийн тусгай хамгаалалтай газар тарвага нутагшуулах боломжтой газрыг аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүд, Баянтүмэн сумын БОУХБ нарын хамт үзсэн

Тарвага нутагшуулах ажлыг гүйцэтгэх ажлыг БОАЖЯамны тусгай ан амьтны барих, нутагшуулах тусгай зөвшөөрөл бүхий “Авралын Эрэлд” ХХК мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн болно. /Тухайн байгууллагын тайланг хавсаргав./

Тухайн сэргээн нутагшуулах тарвага нь Амьтны тухай хуулийн 5-р зүйлийн 5.3.9 зүйл, 8-р зүйлийн 8.1, 8.2 заалт, Хустайн нурууны байгалийн цогцолбор газрын бичиг, Байгаль орчин, аялал жуучлалын яамны тусгай зөвшөөрлөөр Тарвага нутагшуулах зохих арга зүйн дагуу эрэгчин-12, эмэгчин-10, мөндөл -3 хүйсийн харьцаатай нийт 25 тоо толгой тарвагыг Хустайн нурууны БЦГазрын Хөх асга, Гүн жаалга гэх нэртэй газраас барьж Хашаатын цав уурхайгаас 65 км орчим зайтай Баянтүмэн сумын 2р багийн нутаг Хутагт уул нэртэй орон нутгийн хамгаалалттай газарт Монгол тарвагыг сэргээн нутагшуулах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн болно.

Нутагшуулах үеийн бүх бодгаль тарвага хэвийн эсэн мэнд сэргээн нутагшуулсан.



Зураг 53. Тусгай зориулалт бүхий тээврийн хэрэгслээр зөөвөрлөгдөн ирсэн тарваганууд



Зураг 54. Тарвага сэргээн нутагшуулах ажлын явц /Хутагт уул /



Зураг 55. Тарвага тавихаар суллаж буй байдал



Тарвага нутагшуулсан ажлын хэсэг баруун талаас: Баянтүмэн сумын БОХУБ Э.Энххэрлэн, Экологийн цагдаагийн төлөөлөл, Меланж ХХК-ний Байгаль орчны мэргэжилтэн З.Хилийнчулуун, Авралын Эрэлд ХХК-ний мэргэжилтнүүд М.Зулбаяр, Биологич Т.Жамсрандорж нар

2. Хашаатын цав хүрэн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаа явагдах талбайгаас ойр орших эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийх Байгаль орчны газрын санал болгосон газарт гүйцэтгэх

Дорнод аймгийн БОАЖГазрын саналыг авч, тухайн газраас санал болгож тогтоож өгсөн бүс нутагт эвдэрч орхигдсон эвдэрсэн 0.7 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн болно. Түүний дагуу Дорнод аймгийн Баянтүмэн сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байршилтай аймгийн төвөөс зүүн урагш 20 км-т байрлах замын карьерын хуучин эвдэрч орхигдсон 0.7 га талбай бүхий эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлтийг 2022.08.13-2022.08.14 хооронд хийж гүйцэтгэсэн болно.

Нөхөн сэргээлт хийх ажилд 50-н ковш 1 ш, 480 эксковатор 1ш, авто трейлер 1 ш техникээр гүйцэтгэсэн. Нөхөн сэргээлт хийсэн талбайг аймгийн БОАЖГазарт 2022.09.15-нд хүлээлгэн өгч, нөхөн сэргээлтийн акт авсан. /Тухайн нөхөн сэргээлтийн актыг хавсаргав./

Хүснэгт 20. Эвдэрсэн газрын газарзүйн солибцол

№	X	Y
1	48° 0'57.22"N	114°44'3.24"E
2	48° 0'58.07"N	114°44'3.38"E
3	48° 0'58.38"N	114°44'3.59"E
4	48° 0'58.42"N	114°44'3.99"E
5	48° 0'57.51"N	114°44'4.44"E
6	48° 0'56.73"N	114°44'5.63"E
7	48° 0'56.50"N	114°44'6.09"E
8	48° 0'55.78"N	114°44'5.96"E
9	48° 0'54.98"N	114°44'5.30"E
10	48° 0'55.18"N	114°44'4.53"E
11	48° 0'55.45"N	114°44'3.59"E
12	48° 0'55.74"N	114°44'2.48"E
13	48° 0'56.39"N	114°44'1.96"E
14	48° 0'56.88"N	114°44'2.00"E
15	48° 0'57.14"N	114°44'2.58"E






Зураг 56. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийхээс өмнөх байдал 2022.07.18.



Зураг 57. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт хийгдэж буй байдал

Техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэсэн тухайн газрын стандартын шаардлага хангасан тухайн газарт бэлчээрлэж нутаглах мал, зэрлэг амьтдын аюулгүй байдлыг хангах үүднээс огцом эргийг налуу болгож амьтан орж гарах нөхцлийг бүрдүүлсэн байна.



Зураг 58. Техникийн нөхөн сэргээлт хийгдсэний дараах байдал

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ИРГЭДТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн төсөл хэрэгжиж буй газар нь Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших MV-020936 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хашаатын цав нэртэй хүрэн нүүрсний орд төслийг 2022 оноос хэрэгжүүлэх төлөвлөж байна тус төсөл хэрэгжиж эхэлснээр орон нутгийн иргэд, оршин суугчдын эрх ашгийг нэн тэргүүнд тавьж тэдний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжид онцгой анхааран ажиллах болно.

Хүснэгт 21. Нөлөөллийн бүст ажиллах төлөвлөгөөний хэрэгжилт

Нөлөөллийн бүст ажиллах төлөвлөгөө	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Хамрах хүрээ
Уурхайн нөлөөллийн бүсийн айлуудад хамтран ажиллах, санал бодлыг сонсох	Төслийн талбайн орчимд иргэдтэй уулзах, нөлөөллийн талаарх мэдээллийг өгч, хамтран ажиллах	Хашаатын цав уурхайн ойр орших нөлөөллийн бүсийн айлуудад уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлуудыг танилцуулсан.
	Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн саналыг авах, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, нийгмийн хариуцлагын чиглэлээр хийх арга хэмжээг нарийвчлан тогтоох	Уурхайн гадаад тээврийн зам тавигдах ажилтай холбоотой төслийн нөлөөлөлд өртөх айлуудын асуудлыг тусгайлан шийдвэрлэхээр төлөвлөж байна. Уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа нөлөөллийн бүст нүүлгэн шилжүүлэх ажил үүсэхгүй болно.
	Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс нэмэлт гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй хүлээн авч зохих хэмжээнд нь шийдвэрлэж заавал хариу өгөх.	Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах үднээс Дорнод аймгийн Хөдөлмөр газар, засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж, орон нутгийн иргэдийг шаардлагатай ажлын байраар хангах, аймаг орон нутгаас тавьж буй аливаа ажилд хамтран ажиллах, тавьж буй шаардлагыг биелүүлэн ажиллаж байна.

1. Төслийн талбайн орчимд иргэдтэй уулзах, нөлөөллийн талаарх мэдээллийг өгч, хамтран ажиллах

Хашаатын цав уурхайн ойр орших нөлөөллийн бүсийн айлуудад уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажлуудыг танилцуулах ажлыг Баянтүмэн сумын 2-р багийн 8-н айлд 2022.05.11-05.21-нд тус тус зохион байгуулж “Меланж” ХХК-ний уурхай хариуцсан захирал Д.Өлзийдэлгэр, орон нутаг хариуцсан менежер Б.Болдоо, Хашаатын цав уурхайн Байгаль орчны мэргэжилтнүүд А.Болат, З.Хилийнчулуун нар тухайн төлөвлөгөөг танилцуулсан болно.



Зураг 59. Уурхайн нөлөөллийн бүсийн Баянтүмэн сумын 2-р багийн иргэн Энхбаярт 2022.05.11-нд 2022 оны БОМТ танилцуулсан байдал



Зураг 60. Уурхайн нөлөөллийн бүсийн Баянтүмэн сумын 2-р багийн иргэд 2022.05.21-нд 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө танилцуулсан байдал

1. Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах,

Хашаатын цав уурхайн Байгаль орчны хамгаалах, сум орон нутагтай хамтран ажиллах хүрээнд хэд хэдэн гэрээ байгуулж хамтран ажиллаж байна. Хашаатын цав уурхайд Дорнод аймгийн орон нутгийн иргэд ажиллуулах болон ажилчдыг орон нутгаас хангахад анхаарч Дорнод аймгийн нийгэм, халамжийн газар, аймаг орон нутагтай гэрээ байгуулан ажиллаж байна.

9. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 6 дугаар бүлгийн 17.10 дугаар заалтын дагуу ШУА-ийн Палентеологийн Төвийн судлаач, эрдэмтэд төсөл хэрэгжиж байгаа нутаг дэвсгэрт хээрийн судалгаа хийсэн ба тус судалгаатай холбоотой дүгнэлтийг 2017.06.20 гаргасан ба “Хашаат цав” төслийн ашиглалт явуулж буй талбайд археологийн болон соёлын үнэт зүйл бүхий газар тэмдэглэгдээгүй байна. Уг дүгнэлтэнд тусгай зөвшөөрлийн талбайд тархсан геологийн чулуулаг хурдаснаас эртний түүхэн амьтдын үлдвэр илрээгүй болохыг тодорхойлсон.

Уурхайн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор шинээр илэрвэл тус компани дотоод журмын дагуу бүртгэх журамтай. Хашаатын цав уурхайн хөрс хуулалтын явцад 6-8 саруудад уурхайн RL712-720-735 хоорондын түвшинд илэрсэн чулуужсан мод хэд хэдэн ширхэг илэрсэн. Тухайн чулуужсан модыг хөрс хуулалт хийж буй компаниуд илэрсэн даруйд бүртгэл хөтөлсөн. Тус чулуужсан мод илэрсэнтэй холбоотой Баянтүмэн сумын засаг дарга, БОУХБ холбогдох хүмүүс 2022.08.04-нд тус уурхай дээр ирж газар дээр нь үзэж шалган хянасан. Одоогийн байдлаар тухайн үед гарсан чулуужсан модыг тусгай цэгт цуглуулан хадгалж байна. */Бүртгэл хийсэн талаар мэдээлэлийг тайланд хавсаргав./*

Хүснэгт 22.Түүх, соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээ	Тайлбар
Уурхайн олборлолтын явцад тогтоогдсон палеонтологийн олдворыг нүүлгэн шилжүүлээгүй тохиолдолд түүхийн дурсгал сүйдэх	Олдворыг сумын засаг даргын тамгын газарт 7 хоногийн дотор, сум засаг дарга 3 хоногийн дотор улсын бүртгэл мэдээллийн санд холбооны хэрэгсэл, албан бичгээр мэдэгдэж бүртгэнэ. Бүртгэсэн олдворын эргэн тойронд хамгаалалтын бүс байгуулж, хөнөөл учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Түүх, соёлын олдвор, дурсгалыг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийг холбогдох мэргэжлийн байгууллага, орон нутгийн удирдах байгууллага, олон нийтийн оролцоотойгоор боловсруулж хэрэгжүүлнэ Үнэт ач холбогдол бүхий палеонтологийн олдворыг зөөвөрлөнө. Энэхүү ажиллагааг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ Монгол улсын ШУА-ын Палеонтологийн төвийн лабораторитой хамтарч ажиллаж шилжүүлж судалгааны ажлыг дэмжиж ажиллана	Уурхайн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор шинээр илэрвэл тус компани дотоод журмын дагуу бүртгэх журамтай. Уурхайн 720-735 түвшинд илэрсэн чулуужсан модын тухайн гүйцэтгэгчийн талбайгаас илэрсэн тухай бүрд нь бүртгэл хөтөлсөн. Тус чулуужсан мод илэрсэнтэй холбоотой Баянтүмэн сумын засаг дарга, БОУХБ холбогдох хүмүүс ирж газар дээр нь үзэж шалган хянасан. Уурхайд тухайн үед гарсан чулуужсан модыг тусгай цэгт одоогийн байдлаар цуглуулан хадгалж байна.

Төслийн болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх үйл ажиллагаанаас археологи, палеонтологийн өв санд сөрөг нөлөө үзүүлэх	Соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр дахин археологийн судалгаа хийж үр дүнг мэдээлнэ	Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн 6 дугаар бүлгийн 17.10 дугаар заалтын дагуу ШУА-ийн Палентеологийн Төвийн судлаач, эрдэмтэд төсөл хэрэгжиж байгаа нутаг дэвсгэрт хээрийн судалгаа хийсэн ба тус судалгаатай холбоотой дүгнэлтийг 2017.06.20 нд гаргасан ба “Хашаатын цав” хайгуулын талбайд одоогийн төслийн ашиглалт явуулж буй талбайд археологийн болон соёлын үнэт зүйл бүхий газар тэмдэглэгдээгүй байна. Уг дүгнэлтэнд тусгай зөвшөөрлийн талбайд тархсан геологийн чулуулаг хурдаснаас эртний түүхэн амьтдын үлдвэр илрээгүй болохыг тодорхойлсон.
	Судалгааны ажлыг эхлүүлэхээс 1-2 сарын өмнө палеонтологи болон археологийн мэргэжлийн зөвлөлд судалгааны хөтөлбөрийг бэлтгэж өгнө	
	Түүх, соёлын үнэт олборын эргэн тойронд хамгаалалтын бүс байгуулах ба томоохон хөнөөл учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно	
	Уурхайн малталт, нүүрс боловсруулах ажиллагаа нь палеонтологийн үлдэц, судлагдаагүй археологийн олдворуудад шууд нөлөөлөх тул энэхүү асуудлыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж чухал ач холбогдол бүхий үнэт зүйлсийг зөөвөрлөнө	
Төслийн болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх үйл ажиллагаанаас археологи, палеонтологийн өв санд сөрөг нөлөө үзүүлэх		

Үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор шинээр илэрвэл газар шорооны ажлыг түр зогсоож мэргэжлийн байгууллагад хандан судалгаа хийлгэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллана. “Ашигт малтмалын тухай” хуулийн 41.1–дэх “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” заалтыг мөн 2022 онд мөрдөн ажилласан.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших Хашаатын Цав нэртэй хүрэн нүүрсний орд нь химийн хортой бодис материал ашиглахгүй юм. Уурхайн 2022 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан түүний дагуу яамар нэгэн аюул, осол эрсдлээс сэргийлэх арга хэмжээг тухайн үед хэрэгжүүлэн ажилласан байна. Уурхайн талбайд галын аюул гарч болзошгүй тул гүйцэтгэгч компани болгон гал унтраах багаж хэрэгслийн хангамж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажилласан. Мөн ажилчдын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаатай холбоотой анхааруулах самбар тэмдэглэгээг үйлдвэрийн шаардлагатай хэсэгт байршуулсан.

Болзошгүй аюул, осол	Сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээ	Биелэлт
Галын аюул: Барилга байгуулалтын үед ашиглагдах химийн бодисууд дотор ахуйн болон үйлдвэрлэл, техникийн зориулалттай олон тооны шатах, тэсрэх болон хялбархан исэлддэг бодисууд хэт халалтын улмаас тэсрэх, дэлбэрэх, исэлдэх зэрэг эрсдэл учруулах Аянга, цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр тэсэрч дэлбэрэх, галын аюул	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, журам боловсруулж түүнийг дагаж мөрдөх	“Хашаатын цав” нүүрсний уурхайд тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, гал түймэр, тэсрэлт дэлбэрэлтээс хүн ам болон хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах хойшлуулшгүй сэргээн босгох, гамшигт нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах үед мөрдөн ажиллах “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.
	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарч болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах	MNS 5566: 2020 Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм-ын дагуу Амрах байр, засварын төв, оффис-ын орчим галын сарай бүр техник тээврийн хэрэгсэл болон шаардлагатай бүх газруудад гал унтраагуур байрлуулж сар бүр тогтмол үзлэг шалгалт хийж байна. Мөн тамхины цэг байгуулж бусад газруудад тамхи татахыг хориглоно, ил гал гаргахыг хориглоно тэмдэг, санамжуудыг байрлуулсан.
	Тэсэрч дэлбэрэх аюултай түлш, шатах тослох материалыг нарны шууд тусгалаас хамгаалсан байгууламжид байрлуулах, хамгаалалтын чанга дэглэм тогтоох;	Уурхайн ШТС-г тусгай зөвшөөрөлтэй компани хийж стандартын дагуу гүйцэтгэсэн.
	Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байрлуулах	Уурхайн кемпийн бүс, засварын төвүүдэд аянга зайлуулагч хийсэн.
Газар хөдлөл	Төслийн талбай газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд байдаггүй боловч барилга байгууламжийн байршлыг холбогдох төрийн захиргааны	Гамшгийн эрсдэлийн үнэлгээгээр газар хөдлөлтийн аюул тохиолдох магадлал “ховор болдог” буюу “D” түвшинд үнэлэгдэж байна. Компанийн хөнгөн метал карказтай байр, гэр, чингэлэг сууцад эвдрэл

	байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр төлөвлөхөд	гэмтлийн зэрэг “бага” буюу “IV түвшин” байна.
Үйлдвэрлэлтэй холбоотой осол	Бохир усны шугам хоолой цоорч хөрсөн бүрхэвчийг бохирдуулах эрсдэлтэй тул дамжуулах шугам, хоолойг байнга шалгах шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийх	Уурхайн кемпийн ахуйн бохир усыг 40-60 тн-ны тусгай савыг газрын доор суурилуулсан. Тухайн компаниуд бохир ус нийлүүлэх гэрээг аймгийн төвийн НАА газартай байгуулан тухайн гэрээний дагуу бохир усыг соруулан зайлуулж байна.
	Цахилгааны тоног төхөөрөмж, гэрэлтүүлгийн угсралт монтажийг галын онц аюултай байгууламжид зориулсан стандартын дагуу хийж тогтмол шалгах	Уурхайн кемпийн болон засвар үйлчилгээний талбайн
	Шатахууны агуулахын монтажны бүрэн бүтэн байдалд хяналт тавих	Уурхайн ШТС-г тусгай зөвшөөрөлтэй компани хийж стандартын дагуу гүйцэтгэсэн
	Галын аюулаас хамгаалах болон ил гал гаргахыг хориглосон анхааруулсан тэмдэг, санамж, зурагт самбар, тэмдэглэгээ хийх	Уурхайн кемп болон засвар үйлчилгээний талбайнуудад галын аюулаас хамгаалах болон ил гал гаргахыг хориглосон анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ холбоотой газруудад байршуулсан байна.
	Осол гарсан үед хэрэгжүүлэх нарийвчилсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	2022 оны Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.
Хүчиллэг урсац бий болох	Байнгын хяналт тавих, ажилчдад сургалт явуулах	Хашаатын цав уурхайн нүүрс одоогоор гарч эхлээгүй байна. Хүчиллэг тунадас нь агаарын найрлага дахь хүхэрлэг хий (SO ₂), азотын ислүүд (NO _x) нүүрсхүчлийн хий, цас, борооны усанд уусч, сул хүчил болох нүүрсний хүчил үүсгэсний үр дүнд хүчиллэг тунадас үүсэх гол эх үүсвэр болдог. Уурхайн орчны хяналт шинжилгээний үр дүнгээр тухайн хийнүүд харьцангуй стандарт түвшингээс бага байна.
	Хаягдал дахь сульфидын эрдсийг багасгах	

1. Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, журам боловсруулж түүнийг дагаж мөрдөх.



“Хашаатын цав” нүүрсний уурхайд тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, гал түймэр, тэсрэлт дэлбэрэлтээс хүн ам болон хүрээлэн буй орчныг урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах хойшлуулшгүй сэргээн босгох, гамшигт нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах үед мөрдөн ажиллах “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

2. Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарч болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг, тэмдэглэгээг байрлуулах

MNS 5566: 2020 Аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм-ын дагуу Амрах байр, засварын төв, оффис-ын орчим галын сарай бүр техник тээврийн хэрэгсэл болон шаардлагатай бүх газруудад гал унтраагуур байрлуулж сар бүр тогтмол үзлэг шалгалт хийж байна. Мөн тамхины цэг байгуулж бусад газруудад тамхи татахыг хориглоно, ил гал гаргахыг хориглоно тэмдэг, санамжуудыг байрлуулсан.

3. Тэсэрч дэлбэрэх аюултай түлш, шатах тослох материалыг нарны шууд тусгалаас хамгаалсан байгууламжид байрлуулах, хамгаалалтын чанга дэглэм тогтоох;

Уурхайн ШТС-г тусгай зөвшөөрөлтэй компани хийж стандартын дагуу гүйцэтгэсэн.



4. Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байрлуулах

Уурхайн кемпийн бүс, засварын төвүүдэд аянга зайлуулагч хийсэн.

5. Төслийн талбай газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд байдаггүй боловч барилга байгууламжийн байршлыг холбогдох төрийн захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр төлөвлөхөд

Гамшгийн эрсдэлийн үнэлгээгээр газар хөдлөлтийн аюул тохиолдох магадлал “ховор болдог” буюу “D” түвшинд үнэлэгдэж байна. Компанийн хөнгөн метал карказтай байр, гэр, чингэлэг сууцад эвдрэл гэмтлийн зэрэг “бага” буюу “IV түвшин” байна.

1.2. Газар хөдлөлтөд өртөх байдлын шинжилгээ

Газар хөдлөлтөд хамгийн өртөмтгий, өртөгдсөн үедээ үр дагавар ихтэй объектын нэг бол барилга байгууламж юм. Иймээс эрсдэлийн хэмжээг тодорхойлохдоо барилга байгууламжийн бат бэх чанар, түүнд байгаа хүмүүсийн эрсдэлээр тооцно.

Газар хөдлөлтийн хүч /Рихтерийн шаталбараар/, үүсэх хор уршгийн харьцуулалтын хүснэгтэд үндэслэн Хашаат цав уурхайн ойр орчимд тохиолдож болох V баллын хүчтэй газар хөдлөлтөөс хүн амьтан, барилга, байгууламж, байгаль орчны өртөх байдлын ерөнхий төсөөллийг гаргасан.

Хүснэгт 4.19. Газар хөдлөлтийн хүч, түүнээс үүсэх хор уршиг

Балл нэрэлбэр	Учруулах хор уршиг		
	Хүн амьтанд	Барилга байгууламжинд	Байгаль орчинд
V /хүчтэйвтэр/	Орон байр, байгууламжинд байгаа бүх, гадаа байгаа олон хүн мэдрэнэ. Нойрсож буй хүмүүсийн олонх нь цочиг сэрнэ. Хүмүүс сандрана. Мал, амьтад жигүүртэн үймэлдэнэ.	Байр сууц чинигнэнэ. Онгорхой хаалга, цонх савлана. Дүүжилсэн юмс ойчино. Савтай ус цалгиж асгарна.	Булаг, шандны ундрага өөрчлөгдөж болно.

6. Осол гарсан үед хэрэгжүүлэх нарийвчилсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах

Уурхайн 2022 оны Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.



11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЭЛЭЛТ

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм.

Хашаатын цав уурхайн хог хаягдлын менежментийн хүрээнд цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хог хаягдлыг газар дээр нь ангилан ялгах нөхцөл бололцоог хангаж ажиллах үүрэгтэй. Эзэмшил газрынхаа ойр орчны цэвэрлэгээг тогтмол хийх, үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг тогтоосон цэгт хуримтлуулж тогтмол хугацаанд зайлуулах, ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хаягдлыг ашиглах, аливаа зүйлээр бохирдсон хог хаягдлыг саармагжуулах, галын аюулаас хамгаалах, хадгалалт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалахдаа хогийн сав болон хогийн цэгийг өнгөөр ялгаж зургаар тэмдэгжүүлснээр хуурай хог хаягдлыг стандартын дагуу ачиж, тээвэрлэх хадгалах нөхцөл бүрдэхээс гадна байгаль орчинд сөрөг нөлөөгүй бохирдолгүй амьдрах нөхцөл ханган ажилладаг болно.

Төслийн үйл ажиллагаанаас хатуу, шингэн хог хаягдал гарах ба үүнээс хатуу хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал хэмээн ялгаж тус бүрд нь тохирсон арга хэмжээг авч ажиллаж байна.


Хүснэгт 23. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээ	Биелэлт
Хатуу хог хаягдлыг зориулалтын цэгт ангилан ялгаж хаяагүйгээс орчны бохирдол үүсгэх	Уурхайн үйл ажиллагааны явцад буюу ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг хаях зориулалтын цэг байгуулах	Уурхайн кемп болон засварын газруудад ахуйн хог хаягдлын зориулалтын талбай байгуулж хог хаягдлыг түр хуримтлуулан зайлуулна.
Хатуу хог хаягдлыг зориулалтын цэгт хаяхгүйгээс орчны бохирдол үүсгэх	Хатуу хог хаягдлыг тухай бүр тээвэрлүүлж асгуулах эсвэл ландфил үүсгэх	Ахуйн хог хаягдлыг Дорнод амйгийн Баянтүмэн сумтай байгуулсан Хог хаягдал нийлүүлэх гэрээний дагуу тогтсон маршрутын дагуу тээвэрлэн тогтмол ачиж хүргүүлэн ажиллаж байна.
Аюултай хог хаягдлыг зориулалтын агуулахад ангилан ялгаж хаяагүйгээс орчны бохирдол үүсгэх	Уурхайн үйл ажиллагааны явцад завсар үйлчилгээний төв болон ШТС-аас гарах хог хаягдлыг хаях зориулалтын цэг байгуулах	Уурхайн үйл ажиллагааны явцад завсар үйлчилгээний талбайнуудад аюултай хаягдлын тусгай цэг гарган тохижилт хийж зориулалтын сав хуримтлуулан Аюултай хаягдал авах ААН-д хүргүүлдэг.
Шингэн хог хаягдлаар хөрсөөр дамжих гүний ус, хөрс бохирдох	Шингэн хаягдлыг бага оврын цэвэрлэх байгууламжид хуримтлуулан цэвэршүүлэх	Уурхайн кемпийн үйл ажиллагаанаас гарах ахуйн бохир усыг 60тн тусгай сав сууриулж

	/Атмор ХХК Эжорок ЦБ зөвлөв/	түүнд хуримтлуулан Дорнод аймгийн НАА газартай хийсэн бохир нийлүүлэх гэрээний дагуу соруулдаг болно.
	Халдваргүйжүүлэлт болон тогтмол хугацаанд соруулж хаяж байх	Хог хаягдлын цэгүүдэд тогтмол халдваргүйжүүлэх арга хэмжээ авч ажилладаг болно.

1. Уурхайн үйл ажиллагааны явцад буюу ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг хаях зориулалтын цэг байгуулах

Уурхайн үйл ажиллагааны явцад кемпийн үйл ажиллагаанаас гарах ахуйн хог хаягдлыг хаях зориулалтын цэгийг кемп дотор талбай гарган байгуулж тусдаа хуримтлуулж, ангилан ялгалтаар ашиглах боломжгүй хаягдлуудыг сард нэг удаа Дорнод аймгийн Баянтүмэн суманд байгуулсан гэрээний сумын нэгдсэн төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн зайлуулж байна.



Зураг 61. Уурхайн туслан гүйцэтгэгч “Вертекс Майнинг Партнер” ХХК, “КА групп” ХХК-н кемпийн ахуйн хог хаягдлын тусгай цэг



Зураг 62. Уурхайн туслан гүйцэтгэгч “Эм Вай Си” ХХК, “Талын Ат” ХХК-н кемпийн ахуйн хог хаягдлын тусгай цэг



Зураг 63. Уурхайн гал тогоо, засварын талбай, ШТС зэрэгт хог ангилан ялгах сав байршуулсан байдал

Уурхайн туслан гүйцэтгэгч бүр засвар үйлчилгээний талбайнуудад ахуйн хог хаягдлын цэг байгуулан тухайн цэгт хуримтлуулан хадгалж гэрээний дагуу тээвэрлэн хүргүүлж зайлуулж байна.



Зураг 64. Уурхайн засварын талбан ахуйн хаягдлын хуримтуулах цэг

2. Уурхайгаас гарч буй хаягдлуудыг бүртгэх, ахуйн хог хаягдлыг хэмжээнд хяналт тавих

Уурхайн ахуйн болон аюултай хаягдлыг хадгалах, цуглуулах, хуримтлуулах, зайлуулах журмын дагуу уурхайн бүх төрлийн хаягдлуудыг гүйцэтгэгч компани сар бүр бүртгэл хөтөлж, тухайн бүртгэл Меланж ХХК-ний Байгаль орчны мэргэжилтнүүд хяналт тавьж ажилладаг.


3. Хатуу хог хаягдлыг тухай бүр тээвэрлүүлж асгуулах эсвэл ландфил үүсгэх
 Уурхайн ахуйн хог хаягдлыг хаях зориулалтын цэгт тусгайлан хуримтлуулж, ангилан ялгаж сар бүрийн тогтсон хугацаанд уурхайгаас 83 км зайтай Дорнод аймгийн Баянтүмэн сумын төвийн нэгдсэн хогийн цэгт тээвэрлэн зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэлт хийж зайлуулдаг болно. Гэрээний дагуу Баянтүмэн суманд сард 2.2сая төгрөгийг төвлүүлж байна.



Зураг 65. Уурхайн засварын талбан ахуйн хаягдлын хуримтуулах цэг



Зураг 66. Уурхайн засварын газрын ахуйн хаягдлыг ачуулах явц



Зураг 67. Уурхайн засварын газрын хаягдал дугуй ачуулах явц

4. Уурхайн үйл ажиллагааны явцад завсар үйлчилгээний төв болон ШТС-аас гарах хог хаягдлыг хаях зориулалтын цэг байгуулах

Уурхайн олборлолтын үйл ажиллагааны уурхайн засвар үйлчилгээнээс үүсэх аюултай хаягдлыг бүртгэлжүүлж тусгай зориулалтын савт аюулгүй байдлыг ханган, “уурхайн аюултай хаягдал хадгалах, хуримтлуулах журмын дагуу түр засварын талбайд хадгалж Аюултай хаягдлыг нийлүүлэх гэрээний дагуу хүлээн авч аж ахуйн нэгж рүү хүргүүлдэг. Аюултай хаягдлыг сар бүр бүртгэж нийт тоо хэмжээг гарган бүртгэл хөтөлдөг. Уурхайн кемп болон уурхайн бүсээс гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж, ангиллаар нь өдөр тутам бүртгэж байна. Мөн аюултай хог хаягдал болох агаар шүүгч тосны шүүр зэргийг уурхайн замын тэмдэг тэмдэглээд ашиглаж байна.



Зураг 68. Уурхайн засварын газрын аюултай хаягдлыг хуримтлуулах цэг



Зураг 69. Уурхайн засварын газрын аюултай хаягдлыг ялгасан байдал

5. Шингэн хаягдлыг бага оврын цэвэрлэх байгууламжид хуримтлуулан цэвэршүүлэх /Атмор ХХК Эжорок ЦБ зөвлөв/

Хашаатын Цав уурхайн ажилчдын кемпийн үйлчилгээнд ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж барих судалгаа хийж холбогдох компанид цэвэрлэх байгууламж худалдан авах, барих гэрээ хийгдэхээр болсон. Одоогоор 3-н туслан гүйцэтгэгч компаниуд ахуйн бохир усыг тусгайлан хуримтлуулан соруулахаар зохион байгуулан 40-60 тн-ын сав сууриулсан. Дорнод аймгийн нийтийн аж ахуйн газартай

Бохир ус нийлүүлэх гэрээ 2022.04.14-нд байгуулсан болно. Уурхайн ахуйн бохир усыг тус гэрээний дагуу Дорнод аймгийн НАА-д нийлүүлэн ажиллана.



Зураг 70. Кемпийн талбай дээр газрын доор суурилуулсан бохирын сав болон бохир соруулж буй байдал

Туслан гүйцэтгэгч “Талын Ат”ХХК уурхайн кемпийн гал тогоо, душ, ариун цэврийн байгууламжийг шинээр барьж ахуйн бохир шингэн хаягдлыг цэвэрлэх бага оврын Юнинос маркын бохир цэвэршүүлэгч төхөөрөмжийг суурилуулсан. Ингэснээр бохирыг байгальд шууд нийлүүлэхгүйгээр шүүж саарал ус болгон дахин ашиглах юм.



Зураг 71. “Талын ат”ХХК-н кемп дээр сууриулсан ахуйн бохир Юнинос ус цэвэрлэх байгууламж барисан байдал

6. Халдваргүйжүүлэлт болон тогтмол хугацаанд соруулж хаяж байх

Кемпийн бүсэд хоолны хаягдал, ахуйн бохир ус болон энгийн хог хаягдлуудыг ангилан хаяхаар хогийн цэгүүдийг байгуулсан. Эдгээр хог хаягдлын цэг болон нүхэн жорлонгийн ариутгал халдваргүйжүүлэлтийг 2 хоногт 1 удаа тогтмол хугацаанд гүйцэтгэдэг . Ариутгал хийж буй зургийг доор харуулсан.



Зураг 72. Хогийн цэгт ариутгал хийж буй байдал.

Хашаатын цав уурхайн дотоод журам, байгаль орчинтой холбоотой журмын дагуу уурхайн бүх гүйцэтгэгч компаниуд 7 хоног бүрийн 3 дахь өдөр кемпийн бүс түүний орчим, засвар үйлчилгээний талбай, уурхайн зам болон кемпийн зам талбайг цэвэрлэдэг. Тухайн цэвэрлэгээнд гүйцэтгэгч компанийн бүх ажилчид мөн гэрээт компанийн ажилтан оролцож ажилладаг болно.



Зураг 73. Кемпийн гадна Орчны цэвэрлэгээ хийж буй байдал



Зураг 74. Кемпийн зам дагууд орчны цэвэрлэгээ хийж буй байдал





Зураг 75. Уурхайн ажилчид ээлжит орчны цэвэрлэгээ хийж буй байдал





Зураг 76. Уурхайн засвар үйлчилгээнээс гарах аюултай хаягдлын болох агуур шүүгчийн дахин замын тэмдэг , тэмдэглэгээний зориулалтаар ашиглахаар бэлдсэн байдал



Зураг 77. Уурхайн засвар үйлчилгээний газруудад ангилан ялгалт хийх тавьсан байгаа байлал

Хог хаягдлын менежментийг сайжруулах нийт ажилчдад мэдлэг, мэдээлэл олгох сургалт

Компанийн бодлогын хүрээнд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах бодлогыг баримтлан ажиллаж байгаа тул шинээр ажилд орж буй ажилчдад шинэ ажилтны сургалт, катерингийн үйлчилгээ үзүүлж буй компанийн ажилчдад хог хаягдлын менежмент болон хог хаягдлын ангилан ялгалтын талаарх сургалтыг тогтмол

зохион байгуулдаг. Энэ жилд шинэ ажилтны сургалтаар 1158 ажилтанд хог хаягдлын талаар сургалтанд хамрагдсан байна.



Зураг 78. Уурхайн бүх ажилчдад хог хаягдлын менежментийн сургалт орж байна

12. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Хашаатын цав хүрэн нүүрсний ил уурхайн удирдлага зохион байгуулалт, ажилчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Мөн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлуудыг хариуцан гүйцэтгэх туслан гүйцэтгэгч компани -2, Меланж ХХК-ний байгаль орчны мэргэжилтэн-2 хүн, ХАБЭА -2, туслан гүйцэтгэгч компани тус бүр 3-4 ХАБЭА-н мэргэжилтэн ажилладаг байна.

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах, жилийн эцэст БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, байгаль орчны хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор компанийнхаа дотоод дүрэм, журамд өөрчлөлт оруулах ОБГ, МХГ зэрэг газруудаар үйлдвэр дээрээ хяналт тавиулж, ажилчдынхаа дунд галын аюулгүй ажиллагаа, аюулгүй ажиллах, хөдөлмөр хамгааллын сургалтууд, осол эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах ажлууд:

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүр ажилчдад ажлын байрны онцлог тус бүрд нийцсэн ажлын хувцас хэрэгслийг олгох, жил бүр ажиллагсдаа эмнэлгийн байгууллагатай хамтран эрүүл мэндийн 5-8 төрлийн үзлэг шинжилгээнд хамруулан, нарийн мэргэжлийн эмч нараар ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө өгүүлэх, шаардлагатай тохиолдолд ажилтнуудыг амбулаториор эмчилгээнд хамруулдаг байна.

Мөн машин тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг байрлуулж, цехийн мастерууд ажилд гарахын өмнө ажиллагсдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч ажиллуулж байх, ажилчдын ажлын хувцас, хэрэглэлийг тогтмол хэрэглүүлж занших, ажлын байранд яаралтай үед хэрэглэх түргэн тусламжийн багаж хэрэгсэл, эм тариа бэлтгэх

Хүснэгт 24. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний биелэлт

Д/д	Төлөвлөсөн арга хэмжээ	Хариуцагч компани, ажилтан	Биелэлт
-----	------------------------	----------------------------	---------

1.	БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх	“Меланж” ХХК болон гүйцэтгэгч компаниудын байгаль орчны мэргэжилтэн	БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын жилийн төлөвлөгөө боловсруулан түүний дагуу ажиллаж байна.
2.	Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, хог хаягдлыг аль болох дахин ашиглах, дахин боловсруулах, тээвэрлэх /Ахуйн хог хаягдлыг тээвэрлэх, устгах гэрээ байгуулах/	“Меланж” ХХК болон Баянтүмэн сумын засаг дарга	Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн Дорнод аймгийн Баянтүмэн сумын засаг даргатай Хог хаягдал нийлүүлэх гэрээ байгуулж, гэрээний дагуу сар бүр тээвэрлэн нийлүүлэх болон хог хаягдлын төлбөрийг сар барагдуулан ажиллаж байна.
3.	Аюултай хог хаягдал тээвэрлэх, устгах гэрээ байгуулах	“Вертекс Майнинг партнер” ХХК болон бүх туслан гүйцэтгэгч компаниуд	Хашаатын цав уурхайн гүйцэтгэгч компани бүр аюултай хаягдлыг хүлээн авах эрх бүхий мэргэжлийн байгууллагад гэрээний дагуу нийлүүлдэг. Тодорхой хугацаанд уурхайн засварын талбайд түр хугацаагаар хадгалж байгад гэрээний дагуу өгдөг бол бусад төрлийн хаягдлуудыг уурхайд төрөлжүүлэн хадгалж хог зохиох газарь нийлүүлэн ажилладаг болно.
4.	Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэн тайлагнах	Бүх гүйцэтгэгч компаниуд	Аюултай бүх төрлийн хаягдлыг төрөл бүрээр уурхайн дотоод журмын дагуу тусгайлан бүртгэл хөтөлдөг.
5.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө	“Меланж” ХХК	Хашаатын цав уурхайн 2022 оны БОМТ-г холбогдох яамаар баталгаажуулан авсан.
6.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан	“Меланж” ХХК	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 1 жилийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажлуудыг тухайн бүрт зохион байгуулан ажиллаж байна.
7.	Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавих	“Меланж” ХХК	“Меланж” ХХК-ний Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмын дагуу улирал тутам дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж ажилладаг.


1. БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх

Хашаатын цав уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу тухайн онд хийгдэх байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу жилийн төлөвлөгөө гаргаж түүний дагуу ажиллаж байна.

Бүлг-ийн код	Хог хаягдлын бүлэг	Дэд бүлгийн код	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюул-ын зэрэглэл	Жилд үүсэх хэмжээ (тн, м3, л)	Хадгалагдаж буй нөхцөл					Хуримтлагдсан хэмжээ (тн, м3, л)	Тайлбар
								Зориулалт-ын агуулах	Зориулалтын бус агуулах	Ажлын байр	Ил задгай	Контейнер		
13	Хаягдал тос ба шингэн түлш /хүнсний тос, Д ба Л бүлгийн тос хамаарахгүй/	1301	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тосны хаягдал	130201*	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны бусад тос	А	83 тонн		Ёмкост, 1тн сав				12.0 тн	Ашиглагдсан масло
14	Органик уусгагч, хөргүүрийн шингэн болон хөөс/ аэрозолийн хаягдал (Ё, Ж ангиллын хаягдал хамаарахгүй)	1501	Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	150101*	Хортой бодисоор бохирдсон шингээгч, бохир алчуур, фильтрийн материал	Х	1250 кг		Аюултай хог хаягдлын цэг				155.5 кг	Арчих материал
		1601		160104*	Тосны шүүр	А	2150 ш		Аюултай хог хаягдлын цэг				233 ш	Тосны шүүр
		1606	Батерей, аккумулятор	160601*	Хартугалгатай аккумулятор, батерей	А	15 ш		Аюултай хог хаягдлын цэг				2 ш	Хаягдал аккумулятор
17	Барилгын болон бусад хаягдал	1801	Эмнэлгийн халдвартай хаягдал	180103*	Цуглуулах, устахад тустай хаягдал	А	30 кг			Ажлын байр			6.5 кг	Эмнэлгийн аюултай хаягдал
				150101*	Агаар шүүгч	Х	600 ш		Аюултай хог хаягдлын цэг				65 ш	Дахин ашиглах хаягдал
					Хаягдал дугуй	Х	100 ш						5 ш	

13. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт MV-020936 тус тусгай зөвшөөрөл бүхий хүрэн нүүрсний ил уурхайн ашиглалт, олборлолтыг 2021 оны 12 сараас эхлэн уурхайн явуулж байна. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаарын тоосжилтыг сар бүр, усны хяналт шинжилгээг сар бүр, хөрсний шинжилгээг улирал тутам мөн мэргэжлийн байгууллагын хөндлөнгийн хяналтыг 2 удаа хэрэгжүүлэн зохион байгуулахаар журамд тусгагдсан байдаг.



Зураг 79. Уурхайн орчны хяналт шинжилгээний ажил гүйцэтгэх явц

Уурхайн хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хяналтыг 2 удаа 4 сар, 9 сард “Хашаатын цав”-ын хүрэн нүүрсний уурхайн бүх туслан гүйцэтгэгч бүрийн /”Вертекс Майнинг партнер” ХХК, “МУС” ХХК, КА групп, Талын Ат ХХЗ / хяналтын цэгүүдэд Дорнод аймгийн Цаг уур, орчны шинжилгээний төвийн мэргэжлийн баг бүрэлдэхүүн хийж гүйцэтгүүлсэн байна. Мөн уурхайн туслан гүйцэтгэгч компани бүр сар бүр Агаарын чанарын хяналт шинжилгээ, гүний худгийн усны хяналт-шинжилгээ, улирал бүр хөрсний хяналт шинжилгээний ажлуудыг гүйцэтгэсэн ажилладаг болно.

Хяналт-шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлж тухайн шинжилгээний үр дүнд суурилсан сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 25. Хашаат цавын хүрэн нүүрсний ил уурхайн агаарын чанарын хяналтын цэгүүд

Гүйцэтгэгч компани	Шинжилгээ явуулах төрөл, арга хэлбэр	Хяналтын цэгүүд	Арга, аргачлал	Хугацаа	Мэргэжлийн байгууллага
“МҮС” ХХК-н	Агаарын чанар (нийт Тоосжилт, NO ₂ , SO), хөрсний хүнд ме болон агрохимийн шинжилгээ	<ul style="list-style-type: none"> Уулын карьер Засварын талбай Тээврийн зам Гадаад овоолго Шимт хөрс Кемп 	Автомат багаж DUST TRACK-8520	сар бүр	Дорнод аймгийн Ус, цаг-уур, орчны шинжилгээний төв
“Вертекс Майнинг партнер” ХХК-н	Агаарын чанар (нийт Тоосжилт, NO ₂ , SO), хөрсний хүнд ме болон агрохимийн шинжилгээ)	<ul style="list-style-type: none"> Уулын карьер Засварын талбай Тээврийн зам Гадаад овоолго Шимт хөрс Кемп 	Автомат багаж DUST TRACK-8520	сар бүр	Дорнод аймгийн Ус, цаг-уур, орчны шинжилгээний төв
“КА групп” ХХК	Агаарын чанар (нийт Тоосжилт, NO ₂ , SO), хөрсний хүнд ме болон агрохимийн шинжилгээ	<ul style="list-style-type: none"> Уулын карьер Засварын талбай Тээврийн зам Гадаад овоолго Шимт хөрс Кемп 	Автомат багаж DUST TRACK-8520	сар бүр	Дорнод аймгийн Ус, цаг-уур, орчны шинжилгээний төв
“108 ойл” ХХК	Агаарын чанар (нийт Тоосжилт, NO ₂ , SO), хөрсний хүнд ме болон агрохимийн шинжилгээ	<ul style="list-style-type: none"> ШТС 	Автомат багаж DUST TRACK-8520	сар бүр	Дорнод аймгийн Ус, цаг-уур, орчны шинжилгээний төв

11.1. АГААРЫН ЧАНАРЫН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

Уурхайн гүйцэтгэгч комданиудын хяналтын цэгүүдэд мэргэжлийн байгууллагаар 1 өдрийн агаарын тоосжилтыг /20 минутын турш/АНУ-д үйлдвэрлэгдсэн DUSTTRACK-8520 багажаар 20 минутын хугацаатайгаар PM 10, PM 2.5 тоосонцорыг, хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/-ийн дээжийг Япон улсад үйлдвэрлэгдсэн агаараас дээж

авахад зориулагдсан автомат дампын багажаар 20 минутийн сорьц авч хийлгэсэн агаарын тоосонцрын pm-2.5, pm-10.0, нийт тоосонцорын хэмжээг дараах хүснэгт харуулав.



Агаарын нийт тоосонцор хэмжих DUST TRAK DRX 8530



Агаар дахь хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/-ийг тодорхойлогч багаж



Зураг 80. Хашаат цав уурхайн агаарын тоосжилт хэмжих буй байдал “Вертекс Майнинг Партнерс” ХХК-ийн үүрхайн агаарын хяналт

Агаар дахь нийт тоосонцрын дундаж агууламж хэмжилтийн цэгүүд 20 минутын хугацаанд хэмжилт хийсэн талбайнуудын нийт тоосонцорын хэмжилтийн утгыг Монгол улсын стандарттай харьцуулж үздэг.

Төслийн талбайн нийт тоосны түвшин:

20 минутын хугацаанд хэмжилт хийсэн талбайнуудын нийт тоосонцорын хэмжилтийн утгыг Монгол улсын стандарттай харьцуулж доорх графикт харуулав. Нийт хугацааны хэмжилтийн дундаж утгыг Монгол улсын агаарын чанарын стандарттай харьцуулж харвал уурхайн карьерийн тоосжилт хүлцэх хэмжээнээс 3срд 3.2 дахин их байсан бол бусад талбайн тоосжилтийн нийт хугацааны дундаж нь стандартын хүлцэх хэмжээнд байна.




График 4. “Хашаатын цав” уурхайн агаар дахь тоосонцорын хэмжилтийн дундаж утга, сарын өссөн дүнгээр

Хашаатын цав уурхайн нийт тоосны хэмжилтийн үр дүнг сарын өссөн дүнгээр харвал 3 дугаар сард уурхайн карьерийн тоосжилт 2 дугаар сарын хэмжилтийн утгаас 14.68 дахин; кемпийн замын тоосжилт 12 сарын үзүүлэлтээс 16.56 дахин, 2 сарынхаас 1.7 дахин; засварын төвийн тоосжилт өмнөх сарынхаас 2 дахин ихэссэн үзүүлэлттэй байна.

✚ Хэмжилт хийсэн талбайн бүдүүн ширхэглэгт (PM10) тоосонцор:

20 минутын хугацаанд хэмжилт хийсэн талбайнуудын бүдүүн ширхэглэгт (PM10) тоосонцорын хэмжилтийн утгыг Монгол улсын стандарттай харьцуулж доорх графикт харуулав. Доорх үр дүнгээс харахад нийт хугацааны бүдүүн ширхэглэгт тоосонцорын хэмжилтийн дундаж утгыг Монгол улсын агаарын чанарын стандарттай харьцуулж харвал 2021 оны 12 дугаар сард уурхайн технологийн замын нарийн ширхэглэгт тоосонцор стандартаас 3.76 дахин давсан. 2022 оны 2 дугаар сард уурхайн технологийн замын нарийн ширхэглэгт тоосонцор стандартаас 1.38 дахин, кемпийн замын тоосжилт 1.99 дахин их байсан ба 3 дугаар сард уурхайн карьерийн тоосжилт хүлцэх хэмжээнээс 12.6 дахин; кемпийн замын тоосжилт 3.2 дахин их байсан бол бусад талбайн тоосжилтийн нийт хугацааны дундаж нь стандартын хүлцэх хэмжээнд байна.




График 5. Хэмжилт хийсэн талбайнуудын агаар дахь нарийн ширхэглэгт PM2.5 тоосонцорын агууламжын дундаж утгыг Монгол улсын стандарттай харьцуулсан байдал.




График 6. 6 сарын хэмжилт хийсэн талбайнуудын агаар дахь нийт тоосонцорын агууламжын дундаж утгыг Монгол улсын стандарттай харьцуулсан байдал.

06 сарын хэмжилтийн дундаж утгыг Монгол улсын агаарын чанарын стандарттай харьцуулж харвал технологийн замын тоосжилт 1.4 дахин их байсан бол бусад талбайн тоосжилтийн нийт хугацааны дундаж нь стандартын хүлцэх хэмжээнд байна.




График 7. 7 сарын хэмжилт хийсэн талбайнуудын агаар дахь нийт тоосонцорын агууламжын дундаж утгыг Монгол улсын стандарттай харьцуулсан байдал.

7 сарын хэмжилтийн дундаж утгыг Монгол улсын агаарын чанарын стандарттай харьцуулж харвал технологийн замын тоосжилт 1.4 дахин их байсан бол бусад талбайн тоосжилтийн нийт хугацааны дундаж нь стандартын хүлцэх хэмжээнд байна.

Хүснэгт 26. “Вертекс Майнинг Партнерс” ХХК-ийн уурхайн хяналтын цэгүүдийн үр дүн

Хяналтын цэг	Хяналтын цэгүүдийн нэр	04 сарын хяналтын үр дүн			09 сарын хяналтын үр дүн		
		Нийт тоосонцор, мкг/м ³	Азотын исэл, мкг/м ³	Хүхэрлэг хий, мкг/м ³	Нийт тоосонцор, мкг/м ³	Азотын исэл, мкг/м ³	Хүхэрлэг хий, мкг/м ³
1 - хяналтын цэг	Шимт хөрсний овоолго	1.0	11.0	4.0	-	-	-
2 - хяналтын цэг	Карьер-01	10.0	25.0	9.0	-	-	-
	Карьер дотор	3.0	14.0	5.0	726.0	14.0	18.0
	Карьер тэлэлт	27.0	42.0	4.0	609.0	31.0	11.0
3- хяналтын цэг	Гадаад овоолго / Отволь/	30.0	40.0	5.0	15.8	20.0	10.0
